

**ХБНГУ-ын Саксон орны (Дрездений) Хернхүтийн сүм
хийдийн архив дахь тод бичгээр буй "Увш хун тайжийн
тууж"-ийн эх бичгийн харьцуулсан судалгаа**

Ш.Чоймаа (МУИС)

Монголын эртний уран зохиолын дотор хэмжээ нь бага боловч хэл найруулга, зохиомж, агуулгаараа нэлээд өвөрмөц зохиолын нэг бол "Монголын Увш хун тайжийн тууж" юм. Академич Ц. Дамдинсүрэн "Энэ тууж, шарын шашин хүчтэй дэлгэрч байх үед бичигдсэн боловч шашны нөлөөнд огт автагдсангүй. "Нууц товчоо", "Жангар"-ын адилаар дайчин цогтой, яруу сайхан хэлээр бичигдсэн байна. Үүний хэл нь жинхэнэ шүлэг, үргэлжилсэн зохиол хоёрын завсрын цагаан шүлэг буюу толгой холбосон үргэлжилсэн зохиолын байдалтай байна. Анх эхлээд амаар зохиогдсон уу, эсвэл бичгээр зохиогдсон алиныг үүгээр шийдвэрлэх аргагүй байна. Анх амаар зохиогдоод дараа нь бичигдсэн байж болох юм. "Убаши хун тайжийн тууж" бол XVI зууны үеийн Монголын шилдэг зохиолын нэг болно"¹ гэж бичсэн байдаг.

Бидний үед, тод бичгээр бичсэн чамлахааргүй их өв уламжилсан боловч, ихэнх нь орчуулгын зохиол, түүнчлэн уул усны сан гэх мэт зан үйлийн судар ном голлож байдаг бөгөөд энэ тууж шиг баруун Монголд анх зохиогдсон, тод бичгээр бичигдсэн түүхэн сэдэвт уран зохиол тун ховор билээ.

Бид энэ зохиолыг академич Ц.Дамдинсүрэнгийн кирилл үсгээр хэвлүүлсэн 1956 оны товхимол болон 1959 онд хэвлүүлсэн "Монгол уран зохиолын дээж зуун билиг оршвой" (монгол бичгээр) номоос үзэж, мэддэг. Судлаачид 1858 онд Галсан Гомбоевийн хэвлүүлсэн тод бичгийн эхийг бас ашигласан байдаг.

Академич Б.Ринчен МУИС-д багшилж байхдаа "Увш хун тайжийн тууж"-ийг 1948 онд хэвлүүлэхээр бэлтгэж, өөрийн гараар тод үсгээр сийрүүлэн бичиж үлдээснийг ахмад багш Д. Жамбаажамц Монголын

¹ "Убаши хун тайжийн тууж", Ц. Дамдинсүрэн хэвлэлд бэлтгэв, Улаанбаатар, 1956, 6-р тал.

эртний уран зохиолын хичээл заахдаа үзүүлдэг байсан билээ. Миний бие 1970-аад оны сүүл үед МУИС-ын Монгол хэл шинжлэлийн тэнхимийн хуучин ноорог цаасан дотроос академич Б. Ринчен гуайн тод үсгээр бичсэн цөөн хуудас гар бичмэлийг олж авсан. Тэр нь дээр өгүүлсэн "Увш хун тайжийн тууж"-ийн оршил нь байсан бөгөөд АЗ хэмжээтэй том цаасан дээр, ягаан чернил, төмөр үзгээр тун тохитой, тод үсгээр өөрөө бичсэн эх бичиг байлаа.

Тэрхүү оршилд өгүүлэхдээ, "Монгол Ард Улсын Их сургуулийн Монгол хэл бичгийн тэнхимд худам монгол, тод монгол бичиг үсгийг судлахад зориулж, монгол утга зохиолын зүйлээс бичмэл ном судар цуглуулсаар буйн дотор тод үсгийн хуучин зохиолоос энэ "Шолой Увш Хунтайж, Дөрвөн Ойрдтой байлдсан түүх" гэдэг дууныг олон оюутныг судалж үзэхэд хэрэгтэй гэж, ЗХУ-ын ШУА-ийн гишүүн эрдэмтэн, академич Козин абугайн удиртгалын өгүүлэлтэй хамт хэвлэв. Козин абугай, энэ түүх дууныг оросоор тун сайхан орчуулаад, академийн "Зөвлөлтийн дорнодахины судлал" гэдэг сэтгүүл бичигт дарамлажээ. ..." хэмээгээд, тэрхүү С.А.Козины орчуулгын удиртгалыг орчуулан тавьжээ.

Академич Б.Ринчен гуай С.А.Козины орос орчуулгын удиртгалаар бамбай болговол, уг туужийг тод үсгээр нь саадгүй хэвлэх магадгүй гэж бодсон болов уу. Б.Ринчен гуай оршлынхоо төгсгөлд "Энэ түүх дуун, тод үсгийн монгол утга зохиолын зүйлээс анх удаа хэвлэгдэж буй бөгөөд, дараа нь тус хэл бичгийн тэнхимээс тод үсгийн Гэсэрийн хэдэн бүлэг зэрэг хэд хэдэн зүйлийг хэвлэхэд бэлэн болгосугай, мөн нийтлэх болно" гэж бичжээ.

МУИС-д "Монгол хэл бичгийн тэнхим" байгуулагдаж, анхны тэнхимийн эрхлэгчээр нь академич Б.Ринчен гуай томилогдон ажиллаж байсан бөгөөд тэр үеэс л монголын эртний сурвалж бичиг, эх бичгийн судлалд анхаарал тавьж, хэвлэн нийтлэх ажлыг төлөвлөж байсан аж. Гэвч тухайн цаг үеийн үзэл суртлын хатуу хяналт хааж боож байсан нь мэдээж билээ.

Академич Ц.Дамдинсүрэн гуай "Монгол уран зохиолын дээж зуун билиг оршвой" номд хэвлүүлсэн "Увш хун тайжийн тууж"-ийн төгсгөлд "Увш хун тайжийн тууж"-ийн Дрезденд байгаа мөн туужийн патиар (гэрэл зураг Ш.Ч)-ыг гол болгож, буриад лам Гомбын Галсангийн хэвлүүлсэн тод үсгийн эх ба Монгол улсын номын санд байгаа уйгуржин монгол үсгийн эхтэй нийлүүлэн засаж хэвлэвэй"² гэж бичсэн байдаг тул академич Ц.Дамдинсүрэн гуайн гол эх болгосон Дрездений "Увш хун тайжийн тууж"-ийн тод бичгийн жинхэнэ эхийг олж үзэх хүсэл аль эрт байсан билээ.

1989 онд Германы Берлин хотын Гумбольдтийн их сургуульд эрдэм шинжилгээний томилолтоор очих үед, миний бие тус сургуулийн монголч эрдэмтдийн сэтгэл зүтгэл гарган тусалсны хүчээр Германы Дрезден муж (одоогийн Саксон орон)-д байдаг Хернхүт (Herrnhut) хэмээх

² Ёе. Damdinsürüng, "Mongjol uran jokiyal-un degeji jayun bilig orosibai", Ulaanbaatar, 1959, 188-р тал

Протестант³ шашныхан суудаг жижиг хотод очиж, хоёр долоо хоног ажиллах боломж олдсон билээ. Ташрамд дурдахад, Дрезден хотод тод бичгийн дурсгал хадгалсан ямар ч газар байхгүй бөгөөд харин тус хотоос их хол Герман, Чех, Польшийн хил орчимд байдаг Хернхүтийн сүм хийдийн архивт тод бичгийн дурсгалууд хадгалагдаж байгаа юм. Тус хотхоны архивийг "Archiv der Evangelischen Brüder-Unität Herrnhut" (Хернхүтийн Евангелийн Ах дүүгийн холбооны архив) гэж нэрлэдэг юм билээ.

1722 онд Evangel-ийн (Протестант) шашны сүсэгтнүүд Хүтберг (Hutberg) уулын бэл хормойд суурьшиж, 1732 оноос анхны Миссионер (Missionar) буюу шашны номлогчоо харь оронд илгээсэн түүхтэй аж. 1735 оноос Африк, Ази, Австрали, Хойт Америк зэрэг дэлхийн янз бүрийн оронд миссионерээ явуулж, тэд багш, эмч, гар үйлдвэрчин, наймаачин зэрэг ажил эрхлэхийн хамт Протестант шашны номлолоо дэлгэрүүлж, бас тэр улс орон, хүн ардын хэл бичиг, шашин соёл, зан заншил зэргийг судалж, тухай тухайн орны хэл бичигт тун сайн суралцдаг байжээ.

Тэрхүү Миссионер нарын цуглуулж ирсэн эд өлгийн зүйл нь их бөгөөд одоо Хернхүтийн угсаатны зүйн музей (Völkerkundemuseum Herrnhut)-д хадгалагдаж байна. Зөвхөн эд өлгийн зүйл төдийгүй сурвалж бичгийн цуглуулга, бас тухайн орны бичиг үсгээр хичээнгүйлэн хуулж бүтээсэн ном судар, өөр хоорондоо харилцаж байсан бичиг захидал зэрэг нь Хернхүтийн сүмийн архив болон угсаатны зүйн музейд хадгалагдаж байна.

Миний бие тус сүмийн оюутны байранд хоёр долоо хоног сууж, тод бичгээр байгаа ном зохиол, захидал бичиг зэрэгтэй танилцаж, бүртгэн авч, судлан үзэхээр зорьж очсон "Увш хун тайжийн тууж"-аа гараар хуулан авсан билээ.

Тус сүмийн архивт байгаа тод бичгийн ном судар, баримт бичиг зэргээс XVIII зууны сүүлийн хагаст холбогдох зүйл нэлээд байх боловч Халимагуудын дунд миссионерээр ажиллаж байсан Шилл Ёханн Готтфрид (1783-1828) гэдэг хүний цуглуулсан болон өөрөө хуулан бичсэн ном судрууд ихэнх нь юм. Мөн түүнд Халимаг хүмүүс ном судар илгээдэг байжээ.

Миний очсон энэхүү Хернхүтийн сүм хийдийн архивд "К 872.Калм" гэсэн шифртэй хайрцагт хадгалагдаж байгаа "Увш хун тайжийн тууж" бол Г.Ё.Шилл (1783-1828) бээр тод үсгийн судраас тун хичээнгүйлэн хуулсан бололтой нэгэн эх юм. 34x11 см хэмжээтэй хөх цаасан дээр хар бэх, төмөр үзгээр нягт нямбай, судар хэлбэрээр бичсэн эх бичиг болно.

14 жилийн өмнө, 14 хоног Хернхүтийн архивд сууж, үг үсгээр нь нягтлан хуулж авсан "Увш хун тайжийн тууж"-ийн тод үсгийн нэгэн эхийг олон жилийн хойно, өдгөө 1858 онд хэвлүүлсэн Галсан Гомбоевийн эх зэрэгтэй тулган харгуулж, үг үсгийн зөрөө ялгаа, нутгийн аялгууны үг

³ Энэ нь Христосын католик шашнаас XVI зууны үед салбарласан Христос шашны нэг урсгал.

хэллэг, хуучирсан эртний үг зэргийг тайлсан тайлбар зүүлт хадаж, ахмад эрдэмтэн Х.Лувсанбалдан гуайн тод үсгийн латин галигийг баримтлан, тухайн сурвалжийн бичлэгийн онцлогийг алдагдуулалгүй галиглав.

“Увш хун тайжийн тууж”-нь монголч эрдэмтэн судлаач нарын бүтээл, толь бичиг тэргүүтэнд олонтаа эшлэгдэж, бас тухайлан судалсан өгүүлэл ч цөөнгүй тохиолддог боловч тод үсгийн жинхэнэ эх бичгийг бүрэн бүтнээр нь эрдэм шинжилгээний галигаар галиглаж, эхүүдийг харьцуулсан судалгаа хийсэн нь өнөө хир үгүй бололтой.

XVI зууны үеийн. Баруун монголын уран яруу хэл найруулгатай нэгэн түүхэн уран зохиолыг, эртний үг хэллэгээр нь, нутгийн аялгууны онцлогоор нь судлаач нарт хүргэх зорилго тавьж, өөрийн үзэж лавласан хэмжээнд тайлбар зүүлт хийн нийтлүүлж байна.

Жич нэгэн зүйлийг дурдахад, уг туужид гарах түүхэн үйл хэрэг, түүхэн бие хүмүүс, зохиогдсон он цаг зэргийн тухай түүхэн сурвалж бичиг болон судлаач нарын судалгааг харьцуулан үзэж, тайлбар хийж болох байсан боловч, өгүүллийн хэмжээ их болох хийгээд нөгөө талаас түүхч бус болохоор осол эндэл болуужин хэмээн эс үйлдэв.

Эрхэм судлаач, уншигч үзэгч абугай нар шүүн тунгаах ажаамуу.

Жич: Академич Б. Ринчен гуайн өөрийн гараар бичсэн “Шолой Увш хунтайж Дөрвөн Ойрдтой байлдсан түүх” хэмээх гар бичмэлийн эхийн нүүрийг хоёр таслан, бас удиртгалын эхнээс өчүүхэн хэсгийг уншигч, үзэгч абугай нарт танилцуулахын тулд өгүүллийн эцэст хавсаргав. Академич Б. Ринчен гуайн тод үсгээр бичсэн удиртгал болон бүхэл зохиолыг хожим хэвлэн нийтлэх санаа буйгаа бас энэ ташрамд мэдэгдсү.

[1a.] mongyoliyin uwaši xon¹ tayji: uulayin xara baras boluqsun urin² xāni sayin mañiq xoyoulān³ xangγayīn xara buloyāsu⁴ xari dōrbūn⁵ oyiridiyigi dayilayā geji nayimin⁶ түмен čereq⁷ morduji irekedēn nalaxu⁸ үкүрийин dabā dabaji nal⁹ xara bōrōqtū¹⁰ nayiman түмен čereq kürji ireji dōrbūn oyiridiyin

¹ Галсан Гомбоев (Г.Г гэж цаашид товчилно.) 3 зүйлийн гар бичмэлийг харьцуулж, 1858 онд тод үсгийн төмөр барын нэгэн эхийг хэвлүүлжээ. Түүний ашигласан "А" хувилбарт "хол", "В" хувилбарт "хул" гэж байсан аж. Мэдээжээр, "хул" (qulug) гэх нь зөв билээ.

² Бидний нийтлүүлж буй Хернхүтийн энэ эхэд "ugin" гэж бичээд, төгсгөлийн "n" үсгийн өмнөх "l" эгшгийг "a" болгож харандаагаар засжээ. Ийм бичлэг хоёр удаа тохиолдов. Мөн энэ эхэд "ugan", "ugul" гэсэн бичлэг бас байна. Г.Г-ын ашигласан гар бичмэлүүдэд мөн тийм бичлэгийн хэлбэр байсныг тэмдэглэжээ. (1-211) Монгол бичгээр "ugγangqai-ugγangqan" гэж бичдэг, халх аялгуугаар мөн "Урианхай~Урианхан" гэж хэлдэг, Монголын эртний нэгэн аймгийн нэрийг Баруун монголчууд "ugānхā" гэж дууддагийг Г.И.Рамстедт (2-450), Ж.Цолоо (3-875) нар тодорхой тэмдэглэжээ. Үүнээс нягталбал, "ugānqān" буюу Урианханы гэсэн оноосон нэрийг салгаж бичсэн бичлэг л энд тохиолдож буй хэрэг юм.

³ Г.Г-ын гурван эхэд "xoyoula" гэж байсан бол энэ эхэд "xoyoulān" гэж байна. Энэ нь Баруун монголын нутгийн аман аялгууны онцлог билээ. Хернхүтийн эхэд ийм онцлог нэлээд буй.

⁴ Г.Г-ын эхэд "bulayāsu" гэж байна.

⁵ "dōrbūn", "dūrbūn" гэж хоёр янзаар бичсэн бичлэг энэ эхэд тохиолдож байна.

⁶ Г.Г-ын эхэд "nayiman" гэх боловч энэ эхэд "nayimin" гэсэн бичлэг цөөнгүй байх ба Г.И.Рамстедтийн Халимаг хэлний тольд "nāṁ, n" (2-273), "нээмн [нээмен]" (4-371) гэж тэмдэглэсэн байна.

⁷ Г.Г-ын эхэд "čeriq" гэсэн бөгөөд Хернхүтийн энэ эхэд байнга "čereq" гэж бичдэг. Энэ нь аман аялгууны тусгал бололтой. Халимаг-Орос толинд "цэрг [цэрег] войско, армия" (4-633) гэж тэмдэглэсэн байна.

⁸ Г.Г-ын эхэд "nalxā" гэж байв.

⁹ "nai хага" гэдгийг Г.И.Рамстедт "Халимаг хэлний толь бичиг"-тээ "kohisčhwarz" (хав хар) (2-270) гэж орчуулжээ. Гэтэл "Халимаг-Орос толь бичиг"-т "нал-широкий (өргөн уудам), нал бөөртг нээмн түмн церг күрэд ирж (фольк.) на широкою всхолмләннүю бурую (букв.чёрную) равнину уже пришло восьмидесятитысячное войско" (4-367) гэсэн байх бөгөөд "Увш хун тайжийн тууж"-аас эшлэсэн нь тодорхой байна. Гэвч энд зөвхөн хам сэдвийн утгаас нь бодож "нал" гэдгийг "широкий" (өргөн уудам) гэсэн бололтой. Учир нь тухайн толь бичгүүдэд "налаа" гэвэл өргөн уудам, задгай гэсэн үг болохыг тэмдэглэсэн байна. "Нал", "налаа" хоёрыг адилтгаж үл болох бөгөөд энэ туужид гарч буй "нал хар" гэдэг үгийг, тодотгуулагч "бөөрөг" гэсэн газар усны дэвсгэр нэртэй нь холбон үзэх ёстой. Монгол хэлэнд өргөн уудам, талархуу газрыг "бөөрөг" гэж нэрлэдэггүй. Харин бөөр шиг дов толгодтой уулын бэл газрыг хэлдэг билээ.

¹⁰ Г.И.Рамстедтийн толь бичигт "bōlōg- sandhügel (элсэн толгой), anhöhe (өндөрлөг, гүдгэр газар), klumpen (бөөм, бөөн)" (2-57) гэж орчуулаад, "бөөрөг толгой" гэдэг үгийг жишээнд авч, уг үг нь орос хэлний "буерак", түрэг хэлний "büiräk-niere (бөөр)" гэдэгтэй гарал нэг болохыг заажээ. "Буерак" гэдэг үгийг Орос-Монгол толь

nutuqtu dörbün анги турсуул талбији олји яадад: mongyoliyin uwaši xon tayiji sayin muu dunda yurбуулан¹¹ чуулгу чуулдэ урин хани sayin majiq ckelen олон sayидууд-ту: uwaši xon tayiji jarliq болбои¹²: jē jaluus¹³, sonosoqtun: dörbün ойиридийин janggeni¹⁴ хотондэн иреқсен dayison-du¹⁵ xoloči morin xotoči noxoi kebtei¹⁶ тарамдаји¹⁷ үлү алддақ биши үү: dörbün ойирид-ту келүүлэд харихона

бичигт үзвэл, “бугор- дов, болдог; бугорок- дов довцог; буерак- жалга, гуу, хонхцог” (8-37) гэж орчуулжээ. Үүнээс үзвэл, монгол хэлний бөөр (böger-e), бөөрөг (bögerüg) гэдэг үг, орос хэлэнд орохдоо, орчин цагийн монгол хэлний урт эгшгийн байрлалд байсан “э+г+э” гэсэн нийлэмжийн “g(r)” гийгүүлэгч нь сулран сугараагүй байх аль эрт цагт оржээ гэж хэлж болох буй заа.

Монгол нутгийн газар усны дэвсгэр нэрд “бөөрөг” гэдэг үг цөөнгүй олон тохиолдох бөгөөд профессор Э.Равдангийн газар усны нэрийн судалгаанаас үзэхэд гол төлөв Увс, Баян-Өлгий, Ховд, Завхан, Говь-Алтай аймгийн нутагт, Ар хулсны бөөрөг, Аралын бөөрөг, Хар бөөрөг, Хар толгойн бөөрөг, Өндөр элсэн бөөрөг, Хэцүү Мааньтын бөөрөг, Шар бөөрөг, Хөх элсэн бөөрөг, Хүүшийн бөөрөг гэх мэт өдий төдий оноосон нэр тохиолдож байна. Я.Цэвэл гуайн “Монгол хэлний товч тайлбар толь”-д “Уулын хажуу этгээдийн дэвсгэр хэлбэртэй газар” (9-99)-ыг “бөөрөг” гэж тайлжээ.

¹¹ Г.Г-ын эхэд “yurбуула” гэж буй.

¹² Г.Г-ын эхэд “bolbai” гэж буй.

¹³ Г.Г-ын эхэд “jaluus” гэж буй. Харин энэ эхэд заримдаа “jaluus” гэж бичжээ.

¹⁴ Энэ нь бичлэгийн эндүү бөгөөд хойноо “janggi” гэж зөв бичсэн буй.

¹⁵ Г.Г-ын эхэд “dayison” гэж бичжээ. Ер нь энэ эхэд үгийн нэгдүгээр үеэс хойших “u” эгшиг баймаар газар “o” бичсэн нь олон тохиолдож байна. Тэдгээр нь заримдаа бичлэгийн ташаарал, заримдаа аман аялгууны онцлог бололтой.

¹⁶ “kebtei” гэдэг нь “адил, шиг, бололтой” гэсэн утгаар ойрд аялгуунд хэлдэг бөгөөд “уг зүйл нь зүйрлэсэн юмны хэв байдалтай ойр төсөр” гэсэн санааг илтгэх ажээ.

¹⁷ “тарамдаји” гэдэг үгийг Ц.Дамдинсүрэн гуай “тарж, сарних” гэсэн үг гэж бодсон бололтой. Улмаар, дараах “ülü aldaday” гэдэг үгийг утга авцалдуулан “үл олддог” (5-184) (6-7) гэж өөрчлөн буулгажээ. “Хоточ нохой шиг тарж сарниж, үл олддог” гэвэл утга зүйн хувьд авцалдахгүй байгаа юм.

Гэтэл “тарамдаји” (тарамдаж) гэдэг нь халимаг хэлэнд өөр утгатай үг аж. Г.И.Рамстедт “Халимаг хэлний толь”-доо, “tarm- die hintere seite der wade (тарам-хөлийн булчингийн ар тал Ш.Ч)”; “tarmdaxa- von hinten die waden angreifen ([нохой] хөлийн булчингийн ар талаас зуухаар дайрах Ш.Ч) “ (2-381) гэсэн утгатай байдгийг тэмдэглэжээ. Орчин цагийн Халимаг-Орос толь бичигт үзвэл; “тарм уст.(хуучирсан) икроножная мышца; нохала наадхла тарм уга үлддг. логов. (нохойтой наадвал хөлийн булчингүй үлддэг) кто играет с собакой, тот остаётся без икроножной мышцы” (4-479) гэж бичсэн нь Г.И.Рамстедтийн тольтой тохирч байна.

Өмнө тайлбарласнаа нэгтгэвэл, “xotondän ireqsen dayison-du xoloci morin xoloci noxoi kebtei тарамдаји үлү алддақ биши үү: (хотондоо ирсэн дайсанд холч морь, хоточ нохой хэвтэй тарамдаж үл алддаг биш үү) гэсэн өгүүлбэр нь “Дөрвөн Ойрдууд ойртон халдаж ирсэн дайсныг сонор сэргэг морь мэт мэддэг; хотоо манаж, гэтүүр хулгайчийг дайран зуудаг нохой шиг ер гэнэдэж автдаггүй” гэсэн утгатай ажээ.

Монгол улсын төв номын санд байгаа “Дөрвөн Ойрад Монголыг дарсан тууж” гэсэн тод бичгээр байгаа товч хураангуй нэгэн эхийг Б.Батмөнх хэвлүүлжээ. Түүнд, дээрх хэсгийг өгүүлэхдээ “Дөрвөн Ойрад нь морин хэвтэй, нохой хэвтэй явдаг буй. Тэр

yayaltai genēta jaluuṣ mini sanaqсан sanā ene: jōbšōrōqtōn xariya buruuṣeqтun¹⁸ yabuya geji uwaṣi xon tayijiyin ene jarligiyin xariugi uulān¹⁹ xara baras болоqсан урин хани sayin majiq urālān²⁰ sūyād uwaṣi xon tayijidu meduulji noyodiyin jarliq jōb bolbo-čigi mongyoliyin uwaṣi [хун тайји (Үүнийг Г.Г-ын эхээс нөхөж оруулав)] урин хāни sayin majiq хойуулан хангyān²¹ хара buluuγāsu²² xari dōrbūn oyiridiyigi ūjūye geji irēd čereq mordoji iribe²³ gekūūgi²⁴ xari xaluun ойиро лоло ken besū²⁵

[1b.] sonosoqсан одоi²⁶ maliyin barāki²⁷ ūjēd ayiji juluji xarixona ūreni ūrendū muu nere sonosoqдаху биyija noyod gebe mongyoliyin sayin muu дунда yurbуулан ötini jōbšōgēd: uwaṣi xon tayiji jarliq bolboi: dōrbūn oyiridiyin nutuq ömnō-čigi биyija qoyino-čigi биyija: alidu²⁸ geji yabunai ta gebe: урин хāни sayin majiq noyodiyin jarliq jōb dōrbūn oyiridiyin nutuq yeke bolbo-čigi nige tibtu xamtu bayidaq: nayiman хонoyār болjoya narṯ хайilyaya gebe: nāru čāru²⁹

нохой болбол хүнтэй адил чоно хулгай ирэх гэж унталгүй манаж байдаг” (7-53) гэсэн нь өмнө өгүүлснийг лав лавдуун болгож байна. Мөн Г.Г-ын эхэд “taramдаji ūlū aldadaq” гэж буй.

¹⁸ Г.Г-ын эхэд “burousāqtan” гэж буй.

¹⁹ Энэ нь аман аялгууг дагуулан бичсэн хэрэг бололтой. Бас “uulayin” гэж бичгийн хэлээр бичсэн нь ч буй.

²⁰ Г.И.Рамстедт “urālān syn. ömērōn - vorwärts (yараш), urālān kīsxэ - vorwärts fallen (yараш ойчих)” (2-450) гэж тайлбарлажээ. Энд “sayin majiq urālān sūyād” гэсэн нь “Сайн Мажиг давшлан суугаад” гэсэн үг болно.

²¹ Г.Г-ын эхэд “xanguayin” гэж буй. Энэ нь өмнө тайлбарласан “uulayin” гэхийг “uulān” гэж бичсэнтэй адил зүйл болой.

²² Г.Г-ын эхэд “bulayāsu” гэж байх нь зөв бичлэг юм.

²³ Г.Г-ын эхэд “irbe” гэж байх нь бичгийн хэлний зөв бичих зүйгээр бол алдаа юм.

²⁴ Г.Г-ын эхэд “gekūyigi” гэж буй.

²⁵ Г.Г-ын эхэд “biṣe” гэж байх бөгөөд “бусад” гэсэн утгаар халимагт хэлдэг байна. Г.И.Рамстедт “biṣe” гэсэн үгийн жишээнд “Архи саваасаан бишээн эвддэг” гэсэн цэцэн үгийг эшлэжээ. Энэ нь “Архи савнаасаа бусдыг эвддэг” гэсэн үг билээ. Энэ хэсгийг Б.Батмөнхийн хэвлүүлсэн эхэд “Холын улс, Ойрадын улс, төрөл улс, төрөл биш улс цуг соносч хэлэлцэж байнай.” (7-53) гэж бичжээ.

²⁶ Г.Г-ын эхэд “odō” гэж буй.

²⁷ Г.Г-ын “А” эхэд “maliyin bayin ūjēd”, “В” эхэд “maliyin barā ūjēd” гэж буй.

²⁸ Г.Г-ын эхэд “alida” гэж байх бөгөөд Хернхүтийн энэ эхийн “alidu” гэх нь зөв болно.

²⁹ “nāru čāru” гэдэг нь “нааш цааш” гэсэн утгатай бөгөөд мөн орчин цагийн халимаг хэлэнд “нааран цааран” гэж хэлж ярьдаг аж. Халимаг-Орос толинд “нааран цааран йовх - шагаты взад и впёрэд” (4-365) гэж тэмдэглэсэн байна. Зүг чиг заасан үг – руу⁴ (uruу) төгсгөлтэй байх нь эртний түрэг хэлэнд ч түгээмэл бөгөөд монгол бичгийн хэлэнд “inaru~пaуaгу, cīnaru~caуaгу” гэж бичдэг.

yabuxu yajariy-ni bi jāsu gebe: nayimin tümen küünēsü³⁰ dayār mededeq xoyor juun³¹ jāluu yaryaya: bum juryān tümen aytāsu dōrbūn juun mori yaryayā: mini jāqsan yajarār yabuji xayituyai³² olbo-čigi ese olbo-čigi nayimin xonoq-tu iretuyai³³ gebe: čuryāran öüni jōbšōgēd qoyor juun turšuuliyigi uulān xara baras³⁴ boloqsan urin xāni sayin majiq dayoulji yarād čeregiyin jaxadu xara oulayin origil dēre yarči xoyor juun turšuldān dōrbūn oyiridiyin nutugiyin jūq jāji ökudēn: ene jūq-tū yabuqtun ömnötön irčös³⁵

[2a.] gedeq yol yarxu irčüsiyigi uruuduqtun dēdü beyeni xara modun dorodu beyeni šara xulusun³⁶ tere xoyouliyin jabsartu māni gedeq yatulyan bi³⁷ tüügēr³⁸ yatulaqtun tere talani ödö uruu xayiqтun töün-dü yumān ese oldomaqča töünēsēn

³⁰ "küün" гэж бичсэн нь тухайн үеийн халимагийн дуудлагатай тохирч байсан хэрэг бөгөөд Г.И.Рамстедт "küñ – mensch (хүн)" (2-249) гэж тэмдэглэжээ. Эрдэмтэн Ж.Цолоо "Ойрд аялгууны толь"-доо, "Баруун Монголын олонх аман аялгуунд монгол бичгийн хэл шиг "küñ" гэж хэлж, ярьдагийг тэмдэглэжээ. "Монголын нууц товчоо"-нд "gü'ün" (10-231) гэж хятадаар галигласан нь XIV зууны эцэс гэхэд хоёр эгшгийн дундах "m" (м) гийгүүлэгч сулран сугарчихсан байсныг харуулж буй хэрэг. Энэ нь өнөөгийн халх аялгууны "хүн" гэдэг үг "küñ → kü'ün → küñ → küñ" гэсэн үе шатаар улирч хувисч ирсний нуталгаа юм.

³¹ Г.Г-ын эхэд "jouñ" гэж буй. Тод бичгийн дурсгалуудын зөв бичлэгийн тогтолцооны дагуу энэ нь зөв билээ. Гэвч Хернхүтийн эхэд "o", "u" эгшгийн тэргүүн үеэс хойш орсон хэлбэрийг сайн ялгаагүй буюу аман аялгууны хэлбэрээр бичсэн зүйл цөөнгүй буй.

³² Г.Г-ын эхүүдэд "xayitayai" гэж буй. Энэ нь ярианы хэлний аман аялгууг дагажээ.

³³ Г.Г-ын эхүүдэд "irtegei" гэж буй. Мөн л аман аялгын онцлог.

³⁴ Г.Г-ын эхүүдэд "bars" гэж бичсэн нь монгол бичгийн уламжталыг дагасан хэрэг буй заа.

³⁵ Г.Г-ын эхэд "ercus" гэж байх бөгөөд одоо оросоор "Иртыш" (Эрчис) гэж хэлдэг гол мөрний нэр билээ. "Монголын нууц товчоо"-нд "erdis" гэдэг энэ гол мөрний оноосон нэр таван удаа гарах бөгөөд "Монголын нууц товчоо"-ны 198-р зүйлд: "tende naiman merkit bolun qamtutcu bayildun yadaju buru'uilan gödölürün erdis ketülürün cubtüsücü olonki-yau usun-tur ökü'üljü'üi. cö'en qaruqsat naiman merkit ertis ketülün baraju qaqacan gödöljü'üi" (10-108) [Тэнд Найман, Мэргид (нэг тал) болон хамтран байлдаж ядаж, буруулан хөдөлж, Эртис гэтлэхдээ цөмөрч унаж, олонхоо усанд үхүүлжээ. Цөөн (амьд) гарсан Найман, Мэргид Эртис гэтлэн туулж хагацан хөдлөв.] (11-215) гэж байх жишээтэй. Эртний монгол хэлний "t", "c" авиа сэлгэж, "t" нь "c" болсон авиан зүйн хувьсал олон байдаг.

³⁶ Г.Г-ын эхэд "xulusan" гэж байх бөгөөд Хернхүтийн эхэд "xulusun" гэж бичсэн нь зөв бичлэг болно.

³⁷ Г.Г-ын "A" эхэд "bi" гэж бичжээ. Мөн хэсэгт гарах "Maani" гэдэг гаталган (усны олом) хаана байдгийг судлаач Б.Батмөнх: "Мааньт гатлага- Энэ нь Зайсан нуурын хойт бие болон Семипалатинск хотын зүүн биед буй Эрчис голын нэгэн том гатлага болно" (7-63) гэж тодолжээ.

³⁸ Энд "tügēr" гэж бичсэн байх боловч мөн хойно нь "tügēr" гэсэн бөгөөд Г.Г-ын эхэд ч "tügēr" гэж буй. Тод бичигт урт "u", "ü" эгшгийг тэмдэглэж ирсэн гол хэлбэр, дүрэм бол "ou" (uu=уу), "öü" (üü=үү) билээ. Тиймийн тул "tügēr" гэж бичсэн нь тод бичгийн зөв бичих зүйд нийцнэ.

ödölös гэд eqčedēn ɣaruqtun: mangyudurni³⁹ asayon⁴⁰-dān usu uuxuta emēliyin⁴¹ aday šara xulusun⁴² gedeq namuyu buluqtai xara uula boldoq töügēr yabuji xayıqtun töün-dü yuman ese oldomaqča tere uuladān⁴³ šidarxan⁴⁴ ireji tasurduq baĵi⁴⁵ ģincilei⁴⁶ xoyor ɣolıyın eken iredeq töügēr xayıqtun: ene ɣurbuulādu yuman ese oldoxona xariĵi ireqtün: čidanasta⁴⁷ bariĵi ireqtön yadanas-ta üjüji ireqtön: oldobo-čigi ese oldobo-čigi nayimin xonoqtu čangyudu yabuji nāru ireji jangġēn öküqtön jē jaluus ta-čigi öülēn⁴⁸ bütēji mendüsen⁴⁹ ireqtün: bi-čigi čereqtēn

³⁹ "mangyudur" гэдэг нь "маргааш" гэсэн утгатай бөгөөд Баруун монголд олон янзаар хэлж дууддаг болохыг Г.И.Рамстедт (2-256), Ж.Цолоо (3-610) нар тодорхой тэмдэглэжээ.

"Монголын нууц товчоо" тэргүүтэй дунд үеийн монгол хэлний дурсгалуудад "manaɣar", "manaɣarsi" гэх мэт хэлбэрүүд тохиолдох бөгөөд "өглөө эрт", "маргааш буюу ирэх өдөр" гэсэн хоёр утгыг заадаг байжээ. "mangyudur" гэдэг нь "manaɣar", "edür" гэсэн хоёр үг нийлж бүтсэн үг юм.

⁴⁰ Энэ үгийг Г.Г-ын эхэд "asxandān" гэж бичсэн бөгөөд "оройдоо, орой үдшийн үед" гэсэн утгатай ойрд нутгийн аялгууны үг болно.

⁴¹ Г.Г-ын "А" эхэд "ämneliyn", "В" эхэд "emeiıyın" гэж байна. Б.Батмөнхийн хэвлүүлсэн товч эхэд "emeiıyēn" (7-44) гэжээ. Энэ голын тухай Б.Батмөнх: "Эмил-Шинжааны Тарвагатай уулаас эх авч, Алаг тугалын нуурт цутгадаг гол юм. Өдгөө энэ голын эх нь БНХАУ-ын ШУӨЗО-ы Тарвагатай аймгийн Эмил шиян (сиян)-д буй бөгөөд харин адаг нь Казакстан улсын нутагт тус тус харьяалагдана" (7-63) гэжээ.

⁴² Энэ газрын нэрийн тухай Б.Батмөнх: "Шар хулстай - БНХАУ-ын ШУӨЗО-ы Тарвагатай аймгийн Толь шияны харьяа нутаг болно" (7-63) гэжээ.

⁴³ Г.Г-ын эхэд "oulada" гэж буй. Энэ нь "ууланд" гэсэн үг.

⁴⁴ Ойрд аялгуунд "šidēr" (3-776), орчин цагийн халимаг хэлэнд "шидр [шидер] а. поблизости, близко б. около, возле, при, у" (4-670) гэж хэлдэг энэ үг нь "ойр, ойрхон" гэсэн утгатай аж. Утгаа монгол бичгийн хэлний "šidar" (шадар) гэдгээс улбаалсан үг юм. "šidarxan" гэдэг нь "ойрхон" гэсэн үг ажээ.

⁴⁵ Энэ голын тухай Б.Батмөнх "Бэжи /бэчи/ - Энэ гол нь Бор талын Хан харангай уулын бэлээс эх авч, Хар талын голд нийлээд Балхаш нуурт цутгадаг байна." (7-63) гэж тайлбарлажээ.

⁴⁶ "ġincilei" гэдэг голын тухай мөн Б.Батмөнх "Гэнжил /гэнчилиг/ - Ангилал голтой нийлээд, Алаг тугалын нуурт цутгадаг багахан гол юм" (7-63) гэжээ. Г.Г-ын эхэд "ġinjili" гэж буй.

⁴⁷ "čidanasta" гэдэг нь аман аялгууны онцлогоор ярианы хэлэнд үг нийлж бүтсэн хэлбэр бололтой. Утгын тухайд, хам сэдэв буюу орчны учир холбооноос нь үзэхэд "чадвал та нар" гэсэн санаа болох нь тодорхой юм. Үгийн бүтэц нь "čidana+abasu+ta(нар)" (чадна+аваас+та нар) гэсэн үгс нийлж товчлогдсон болов уу гэж таамаглаж байна. Өөрөөр хэлбэл, "чадваас та нар", "чадвал та нар" гэсэн утгатай ажээ. Мөн хэдэн үгийн хойно тохиолдох "yadanasta" гэсэн үгийн хэлбэр нь өмнөхтэй адил зүйл болно.

⁴⁸ Г.Г-ын эхэд "üülēn" (үйлээ) гэж байх бөгөөд энэ Хернхүтийн эхэд "öülēn" гэсэн нь аман аялгууны онцлогийг тусгасан хэрэг бололтой.

⁴⁹ "mendüsen" гэдэг үг нь монгол бичгээр буй сурвалж бичгүүдэд ч тохиолддог бөгөөд "mendüsün" гэж бичсэн байдаг (12-1386). Утга нь эрүүл энх, амар мэнд болно. Энэ үгийн гарлын бүтэц нь "mendü", "esen" гэсэн ойролцоо утгат хоёр үг тогтвортой хоршин хэлэгдсээр нийлж, нэг үг мэт болжээ.

xarisu gēd xariba: tegēd sayin majigiyyin jakoqsār⁵⁰ mongyoliyyin turšuul irčüsiyyin māni yātulyār yatulād⁵¹ tere talani ḡdō uruu xayiji yunan ese [2b.] oldaba⁵²: emēliyyin aday šara xulusār xayiba-čigi nutuq ese oldaba: baḡi ginjiliyyin ekēr xayiji yabum geküüne kib būsütei kiling öyimistei⁵³ dolōn nastai⁵⁴ yunun xaltar moritēi köböün xaryaldaba: köböügi öröün⁵⁵ kōgēd asoyon küčüji bariba: qoyor juun turšuul dundān abči souyād janggiyyini suraba: kenē-bi či köböün yuu keji⁵⁶ yabulai či kele köböün gebē:- bayibiyusni bi yesen čayān temēn xayiji yabulai bi gebe:- dōrbūn öyirid čereqtei bui⁵⁷ čereq ügei bui nutuq ni alidu bayinai gebe:- köböün kelebe tani suraḡi ire geqsen biši bariji ire gegsen bišiu⁵⁸: axa-du üge keledēq debeleyin jaḡār ni ömösüdōq⁵⁹ amidu kürküqtün amāran kürji medöülsü gebe :- köböüni ügeni ene: jasaji duu yaryaji yadād jangdaji üge suraḡi yadād ayulyuji-čigi yadād arjaduji-čigi yadād jübčildebei:-

"esen" гэдэг үг нь Алтай хэлний үг бөгөөд эртний түрэг хэлэнд "esän -- здоровый (эрүүл энх), не вредимый (хорлол хөнөөлгүй); esän lükäl – парн (хоршоо үг) здоровый, не вредимый, целый" (13-183) гэж байдаг. Хуучин ном сударт "эсэн түгэл" гэж олонтаа тохиолддог. Орчин цагийн монгол хэлэнд "эсэн мэнд" гэж хэлэх болжээ. Орчин цагийн монгол хэлний "амар мэнд" гэдэг үгийн оронд XIII, XIV зуунд "esen" (эсэн) гэдгийг түгээмэл хэрэглэж байсны нэг жишээг Ил хаан Өлзийт Султанаас 1305 онд Францын хаан Филиппэд илгээсэн албан бичгээс үзэж болно. Түүнд "... qola ber bögesü öyir-a melü sedkijü, alibar üges-iyen öcijü ilcin-iyen esen-ü belegüd-iyen ileldügsed-i yayu endekün ta ..." (14-69,70) [... Хол бээр (хол ч) бөгөөс ойр мэт сэтгэж, аливаа үгсээ өчиж, элчингээ, эсэний бэлгүүдээ (мэнд мэдсэн бэлгээ) илгээлдэгсэдийг юу эндэх та...] гэж байдаг бөгөөд "мэндийн бэлэг" гэхийг "эсэний бэлэг" гэжээ.

Одооны хар ярианы хэлэнд "мэнд усаа мэдэх", "мэнд усаа асуух" гэж ярьдаг нь "мэнд эсэнээ мэдэх" гэдгээс хувирч ирсэн холбоо үг билээ. Үүнд нөлөөлсөн нэг зүйл бол монгол бичгийн хэлэнд нэлээд эртнээс "mendüsün" гэж нэг үг болгон бичдэг болсон уламжлал юм.

⁵⁰ Г.Г-ын эхэд "jakoqsār" гэж буй.

⁵¹ Г.Г-ын эхэд "yatalād" гэж буй.

⁵² Г.Г-ын эхэд "oldubai" гэж буй.

⁵³ Г.Г-ын эхэд "oyimustei" гэж буй.

⁵⁴ Г.Г-ын эхэд "nasutai" гэж буй. Хөрнхүтийн эхэд ихэнхдээ "nastai" гэж бичжээ.

⁵⁵ Ойрд аялгуунд "өглөө" гэдгийг "öröün" (өрүүн) гэж хэлдэг нь монгол бичгийн хэлний "örlüge" гэдэгтэй ойр болох нь илт мэдэгдэнэ.

⁵⁶ Ойрд аялгууны "хийх" гэдэг үгийг "kike, kixe=kexe, kēxe- mačhen (хийх)" (2-231) гэж хэлдгийг Г.И.Рамстедт Халимаг хэлний толь бичигтээ тэмдэглэжээ. Энэхүү эх бичигт байгаа "keji" гэдэг нь "хийж" гэсэн үг болно. Хойшид тохиолдох "kēxü-kekü" гэсэн үгээс хувилсан хэл зүйн үгүүдийг "хийх" гэдэг үйл үгийн язгууртай холбон ухаарай.

⁵⁷ Г.Г-ын эхэд "bi" гэж байх нь бичгийн хэлний "bui"-ийн ярианы хэлбэр "bi" болно. Энэ тухай А.Бобровников "Монгол-Халимаг хэлний зүй"-дээ тодорхой бичсэн бий. (15-147) Энэхүү туужийн эх бичигт тохиолдох "bi" гэдгийг биеийн төлөөний үг "bi" юм уу, "bui" гэсэн үйл үгийн аман аялгууны хэлбэр үү гэдгийг хам сэдвээс нь ухах ёстой.

⁵⁸ Г.Г-ын эхэд "bišiu" гэж буй.

⁵⁹ Хөрнхүтийн энэ эхэд "ömösüdōq" гэж байгаа бол Г.Г-ын эхэд "ömösüdōq bišiyu" гэж буй.

mani suraji ire gegsen biši bariji ire gegsen bilei: öüni amidu kürküyē gēd abād xariba: dörbün oyiridiyin janggi medöül geji xoyor küü⁶⁰ urälän ilgēbe: dörbün oyiridiyin

[3a.] jaxāsu dolōn nastai köböü bariba bida: janggi ni ene gebe: mongyoliyin uwaši⁶¹ ekelen olon sayin muu dunda yurbuulayidu öüni keleji bayitala dolōn nastai köböügi abci irebe: köböügi xatuu ügetei köböün geküügi sonosöd nayimin költei zandan širē dēre ildü suyulad⁶² talbi-ba: uwaši xon tayiji nayimin termeci⁶³ qara čōxor barisiyin⁶⁴ arasār бүрүqsen xos⁶⁵ örködü⁶⁶ dolōn nastai

⁶⁰ "küün" байх ёстой.

⁶¹ Г.Г-ын эхэд "uwaši" гэдэг үгийн хойно "хун tayiji" гэж буй.

⁶² Г.Г-ын эхэд "suyulad" гэж зөв бичсэн буй. Хөрнхүүгийн энэ эхэд элшгийн уртыг заах үүрэгтэй "удааны тэмдэг" гэж тод бичигт нэрлэдэг нэмэлт тэмдгийг орхисон газар цөөнгүй тохиолдож байна.

⁶³ "terme" гэдэг үгийг Г.И.Рамстедт Халимаг хэлний толь бичигтээ "termē-wand wandgitter (хана) russ.(орос) теремь" (2-393) гэж заасан байна. Орос-Монгол толь бичигт үзвэл, "терем- давхарлаг танхим, цамхагт харш, өргөө" (8-715) гэжээ. Эртний түрэг хэлний толь бичгүүдэд тэмдэглэсэн зүйл үгүй бөгөөд В.Радловын "Түрэг хэлний нутгийн аялгууны толь" (1898)-д "tärmä- асар гэр, босоо оройт гэр" гэж бичсэнийг Элдэндэй, Ардаажав нар "МНТ"-ны үгсийн тайлбартаа дурджээ. (16-450) "МНТ"-нд "terme" (тэрэм) гэдэг үг 6 удаа тохиолдох бөгөөд асар майхан, хээрийн өргөө гэсэн утгаар 3 удаа гарч байна. Жишээлбэл "МНТ"-ны 185-р зүйлд: "... qali'udar čaqurqan qoyar činggis - qaһan-a ügülerül ong-qan genet bui altan terme bosqaju qurimlamui ..." (10-94) [Халиудар, Чахурхан хоёр Чингис хаанд өгүүлрүүн: Ван хаан гэнэн (ажиг сэжиггүй) буй. Алтан тэрэм босгож хуримламуи ...] гэсэн хэсэгт "тэрэм" гэж "асар өргөө"-ний утгатай байгаа нь тод байна. Харин "МНТ"-ны 265-р зүйлд: "aša-gambu-yi abcu terme gerü teme'en aci'atu irgen-i inu hünēsü-er keyistele tala'uiba ..." (10-159) [Аша Гамбу-г авч, тэрэм гэрт, тэмээн ачаат иргэдийг үнэсээр хийстэл талуулав ...] гэж байх бөгөөд ханат гэрээ тэмээндээ ачаад нүүдэг Алшаа нутгийнхны тухай энд өгүүлсэн байна. "terme" гэдэг үг монгол хэлнээс орос хэлэнд орсон бололтой.

Энэ үгийг монголчууд эрт үед тун түгээмэл хэлдэг байсны нэг гэрч бол XIII зууны үеийн монгол үгийг хятадаар галиглаж, орчуулга хадсан "žhi-yuan-yi-yu" хэмээх (1264-1294) толь бичигт тэмдэглэжээ. Мөн XIV зууны үеийн, өмнөхийн адил толь бичигт ч бас тэмдэглэсэн байдаг байна. Энэхүү "terme" (tärmä) гэдэг нь эртний монгол хэлнээс эхлэн, 1) хээрийн аяны өргөө, асар майхан, 2) монгол гэрийн ханыг нэрлэдэг үг байжээ.

⁶⁴ Г.Г-ын эхэд "barasiyin" гэж буй.

⁶⁵ "xos" гэдэг нь "хос" гэдэг үгийн нэг хувилбар бөгөөд Г.И.Рамстедт "xos-reisezelt (аяны майхан), sommerküche (зуны гал тогоо), haus für arbeiter (илүү гэр), kkiг. (киргиз) qoš- reisejurte (аяны гэр)" (2-189) гэж Халимаг хэлний толь бичигтээ тэмдэглэжээ.

"МНТ"-ны 169-р зүйлд: "edö'e bida qoyar temüjin-e kelen gürgen yorčiya ke'en üge baralduju merkidei-čaqa'an aman-čaqa'an ke'er qoyar-i bariju irejü huyaju üdesi bü'et qoš-dur-yan niken qurıqa-ban alaju iseri-yer-ən bolqaju ..." (10-80) [Өдгөө бид хоёр Тэмүжинээ хэл хүргэн зорчье хэмээн үг барилдаж, Мэргидэй цагаан, Аман цагаан хээр хоёрыг барьж ирж уяж, үдэш бөгөөд хошдоо нэгэн хурга алж, исэрээрээ (орны модоор) болгож (чанаж) ...] гэж гардаг нь Г.И.Рамстедтийн бичсэнтэй утга тохирч байна.

"МНТ"-ны энэ хэсгийн өгүүлэмжээс үзвэл, Бадай, Хишлиг хоёр Тэмүүжинд нууцаар хэл хүргэх гэж байсан тул илүү жижиг гэр (qoš)-тээ сэмээр хурга төхөөрч, хүнс

köböügi abči irebe: nayimin költei zandan širē dorо sōkōdkūji suulyād qeyer ʔariyini arduni⁶⁷ külātei barun⁶⁸ öbūdōgiyini ualayin xara baras болоқсан уран xāni sayin majiq daraji suun: jōün öbūdōgiyini bāxan čečen daraji suun uwaši xon tayiji köböüni ügēni⁶⁹ suruxudān⁷⁰; jē isla⁷¹ köböün ügeyēn⁷² kele gebe: dōrbōn oyirīd čercqtei bi⁷³ čereq ügei bi yuu keji⁷⁴ bayinai gebe: tegemeqče⁷⁵ köböün uwaši xon tayijidu medүүлji noyod ayilyon⁷⁶ ügei suruqtun⁷⁷ aldal ügei medүүлye xakimnal [=xokimnal Г.Г.] ügei suruqtun⁷⁷ qočirlai⁷⁸ ügei medүүлye: dōrbōn oyirid jarāgiyin üsün körōgiyin šüden bolji
[3b.] dōrbōljin tekelčüq⁷⁹ bayidaq: medeqsēn medүүлye ülü medeqsēn medүүлji bolxu ügei⁸⁰ ülü bayin uwaši xon tayiji köböüni tere ügedü böqdād⁸¹: oyiridiyin nāda jaxadu ken bayinai čercq nutuq bolbo-čigi kele gebe:- köböün medүүлne

бэлдсэн хэрэг юм. "Увш хун тайжийн тууж"-ийн энэ хэсэгт "qoš örkō" (хош өргөө) гэсэн нь аян дайны хөнгөн өргөө гэр буюу асар майхныг өгүүлсэн байна.

⁶⁶ Г.Г-ын эхэд "örgödū" гэж буй.

⁶⁷ Г.Г-ын эхэд "ardani" гэж буй.

⁶⁸ Г.Г-ын эхэд "baroun" гэж буй.

⁶⁹ Г.Г-ын эхэд "ügeyini" гэж буй.

⁷⁰ Г.Г-ын эхэд "suruxadān" гэж байх бөгөөд зөв бичлэг нь "suraxudān" байх ёстой.

⁷¹ Г.Г-ын эхэд "isala" гэж буй. "Хорин наймтын толь"-д: "isel-e edür" (исэл өдөр), "isele sayuqu" (исэл суух) гэж толгой үгэнд аваад, түр чөлөөтэй өдөр, ажилгүй сул суух гэж тайлжээ. (17-296) Ер нь "исэл" гэдэг үг монгол бичгийн хэлэнд "сул, дорой, жирийн зүгээр, гайгүй" гэх мэт утгаар тохиолддог. Энэхүү туужид мөн дээрх утгаар хэдэн удаа тохиолдож байна.

Халимаг-Орос толь бичигт: "исэлэ- усг.(хуучирсан) маленький/малыш (о ребенке)" (8-273) гэж тэмдэглэснээс үзэхэд "jē isla (isele) köböün ügeyēn kele" гэсэн нь "За, балчир хөвгүүн үгээ хэл" гэж басамжлан өгүүлсэн үг юм.

⁷² Г.Г-ын эхэд "ügēn" гэж буй.

⁷³ "bui"-ийн ярианы хэлний дуудлага нь "bi" болно.

⁷⁴ Тайлбар зүүлт 56-г үз.

⁷⁵ Г.Г-ын эхэд "tegemecögēn" гэж буй.

⁷⁶ Г.Г-ын эхэд "ayilyoi" гэж буй.

⁷⁷ Г.Г-ын эхэд "suruqtan" гэж буй.

⁷⁸ Г.Г-ын эхэд "xocohi" гэж буй.

⁷⁹ Г.Г-ын "tekelceq" гэж буй. Г.И.Рамстедт Халимаг хэлний тольдоо "teglseg-ečhig (өнцөгтэй), gebogen (нум мэт), vierēckig (дөрвөн өнцөгт)" (2-390) гэж орчуулжээ. Мөн Халимаг-Орос толинд үзвэл "теглцг [тэгелцег] расположенный квадратами (тэг дөрвөлжнөөр байрласан)" (4-488) гэжээ. Өвөр монголд хэвлэсэн "Ойрд аялгууны үгс" хэмээх номд "бат бэх, зохистой нийцтэй" (19-188) гэж тайлбарлажээ. Бидний нийтлүүлж буй энэ эх бичигт "Дөрвөн Ойрд зарааны үс, хөрөөний шүд болж, дөрвөлжин тэгэлцэг байдаг" гэж гарах бөгөөд утга нь тэгш өнцөгт дөрвөлжин юмыг таавчихсан юм шиг бат бэх, байр суурьтай, нэг дор хамт байдаг гэсэн утгатай хэллэг аж.

⁸⁰ Г.Г-ын эхэд "ügei" гэх үгийн хойно "bayina" гэж буй. Харин ард нь "üü bayin" гэдэг үг алга.

⁸¹ Г.Г-ын эхэд "boqdōd" гэж буй.

amitiyin⁸² nāda jahadu toji⁸³ mönggön duulyatai toburuutu ulān хояаqlai: taji⁸⁴

⁸² Г.Г-ын эхэд "amitiyin" гэж буй. Г.И.Рамстедт Халимаг хэлний толь бичигтээ: "ämtin' " гэж тэмдэглээд "хамгийн" гэсэн утгаар хэрэглэдэг болохыг, "ämtin' dū- der jüngste bruder (хамгийн бага дүү); ämtin' ike- der grösste (хамгийн их); ämtin nādākā- der allernächste (хамгийн ойр)" гэсэн жишээгээр үзүүлжээ. (2-23) Энэ нь бидний эх бичигт яг нийцэж байх бөгөөд "ämtin' nāda jahadu" гэсэн нь "хамгийн наад захад" гэсэн үг ажээ. Орчин цагийн Халимаг хэлэнд ч мөн адил ажээ. Халимаг-Орос толинд "эмтин- самый ...; эмтин ахнь- самый высокий, наивысший; эмтин ик- самый большой, наибольший; эмтин му- самый худший, наихудший; эмтин түрүнд- а) первом делом; б) впереди всех" (4-67) гэх мэт олон жишээгээр тайлбарлажээ. Ц.Дамдинсүрэн гуай "Ойрдын наад захад" гэж буулгасан нь эхтэйгээ зохицохгүй байна.

⁸³ "toji" гэдэг нь "цул, бүхэл, бүгд" гэсэн утгатай алгай хэлний үг бөгөөд орчин цагийн монгол хэлний "tūji" (туж, турш) гэдэг үг мөн бололтой. Өөрөөр хэлбэл, энэ туужид гарч буй "toji mönggön duulyatai" (туж мөнгөн дуулгатай) гэдэг нь "цул мөнгөн дуулгатай" гэсэн үг ажээ. Алтай хэлний баримтыг М.Расенин (Martti Räsänen)-ий "Түрэг хэлнүүдийн гарлын толь бичиг"-ээс эш татъя. Энэ толь бичигт "uig.(уйгур) tosy- all (бүгд); toš- füllen, vollsein (дүүргэх); šor.sag.(шор, цагай) toza- alle insgesamt (бүх нийт); soj.(соёд-соён) doza- все (бүгд); hak.(хакасс) toza- весь (бүх)" (20-491) гэж тэмдэглэсэн нь бидний санааг нутлах буй заа.

⁸⁴ "taji" (таж) гэсэн үгийг Г.И.Рамстедт "Халимаг-Монгол толь"-доо: "утга нь тодорхойгүй" гэж тэмдэглээд, бас "торгоны нэр, хятад гаралтай үг байж магадгүй" гэжээ. (2-373) Бидний энд нийтлүүлэн буй эхэд гарч байгаа "таж" бол торгоны нэгэн зүйлийн нэр бөгөөд, "Таж Махал, Таж Бумбын орон" гэх мэтэд тохиолдох "таж" бус болно.

"Таван зүйлийн үсэг хавсарсан манж үгний толь бичиг"-т "taji" гэдэг үгийг төвд, манж, хятадаар орчуулсныг мөрдөн үзвэл, "хос өнгөтэй, гялалзсан, артай торго" гэсэн утга гарч байна. (18-3155) Мөн энэ үгийн орчимд "artai darda" гэх торгоны нэр байх бөгөөд манжаар "dardan" гэж, төвдөөр "dbyod-Idan" (алтан утас оруулан нэхсэн артай торго) (18-3154) гэж тайлжээ. Сэцэнцогтын "Монгол үгсийн язгуурын толь"-д "taji" гэдгийг "Өнгө дотрыг нь өөр өөр өнгийн ёнхороор ялгаруулан нэхдэг нэгэн зүйлийн торгомсог бараа" (12-1832) гэж тайлбарлаад "taji", "darda" хоёр гарал нэг бололтой гэжээ.

Энэ хоёр зүйлийн торгоны нэр "МНТ"-нд мөн тохиолдох бөгөөд "МНТ"-ны 135-р зүйлд: "... altan e'emek dōrebčitū dasi (taši-taji Ш.Ч) torqan buluqa'ar dotorlaqsan helige(b)čitū üčü'ügen kö'ūken-i a[b]čiraju ..." (10-136) [Алтан ээмэг, дөрөвчит, булгаар доторлосон таж торгон элгэвчит өчүүхэн хүүхдийг авчирч ...] (11-75) гэж буй. "МНТ"-ны 238-р зүйлд "... alīan mönggū subul tanas načil dardas (darda-ийн олон тоо Ш.Ч) torqat abu'at idu'ut iretūgei ..." (10-58) [... Алт, мөнгө, сүвд, тана, начи (хятад орчуулгад "алтат торго" гэсэн ажээ.) дарда торго аваад Идүгүд иртүгэй ...] гэж буй.

torγon ulbutai⁸⁵ tong⁸⁶ cōxor moritei mangyadiyin köböün sayin sērdengkei⁸⁷:
 [xoyor mingγan jaluuyān dayoulaqsan (Үүнийг Г.Г-ын эхээс нөхөн оруулав)]
 xoyor mingγan jidān хадхаqsan⁸⁸ xoyor mingγan morin⁸⁹ soyiji orkiqsan görölkü
 görösön boluu: dayiladaxu dayison⁹⁰ boluu geji šüdēn хабирчи šülüsēn⁹¹ jalgiji
 suudaq: noyoud⁹² töündü duran-tan yambar bayinai: isle⁹³ terečin⁹⁴ γai ügei:
 [töüni cā (=cāna) ken bayidaq bi kele gebe: (Үүнийг Г.Г-ын эхээс нөхөн
 оруулав)] irčüs γoliyin eken-du buuqsan iričin⁹⁵ харчин хойор отойдн⁹⁶ čuqloulji

⁸⁵ Сэцэнцогт "Монгол үгсийн язгуурын толь"-доо "olbu- охор хүрэм, ширмэл буюу "olbuγ" ч гэдэг. Дагуур хэлэнд одоо ч ингэж хэрэглэж буй. "olba" ч гэж бичдэг байжээ." (12-347) гээд, жишээ авахдаа "Увш хун тайжийн тууж"-ийн энд өгүүлж буй хэсгээс эш татжээ. "Хорин нэгт тайлбар толь"-д "Хээр эмсэх охор хүрмийг олбог хэмээмүй." (21-110) гэж тайлбарлажээ. Суудлын дэвсгэрийг "олбог" гэж хэлдэг нь хожмын шилжсэн утга бололтой.

Мөн хуучин цагийн дайн байлдаанд хөө хуягийн дотуур эмсэх зөөлөвч халхавч хувцсыг мөн "olbu-olbuγ-olbu-olbuγ" гэж нэрлэж байжээ. Халимаг-Орос толь бичигт "улв [улвь] уст.(хуучирсан) платье (стёганое, с подкладкой, надеваемое под панцирь)" (4-531) гэж орчуулснаас үзвэл, дайн тулаанд хөө хуягийн дотуур эмсдэг ширмэл богино хувцсыг халимаг хэлэнд "ulbu" гэж хэлдэг байжээ. Энэ эх бичигт "taiji torγon ulbutai" гэдэг нь таж торгон хүрэм мэт хувцсыг нь хэлсэн бололтой.

⁸⁶ "tong" гэдэг нь дараах үгийн утгыг эрчимжүүлэх сул үг "tung"-ын хувилбар бус бололтой. Монгол хэлэнд "тун цоохор" гэж хэлэхгүй, "цов цоохор" гэх ёстой. Тэгвэл "tong" гэж ямар утгатай үг вэ?

Эртний түрэг хэлэнд "toγa 1) леопард (ирвэс), 2) герой (баатар)" (13-575)" гэж байх юм. Үүнээс ургуулан таамаглавал "tong cōxor moritei" гэдэг нь "ирвэс, (барс) цоохор морьтой" гэсэн утгатай ч байж болох юм. Г.Г-ын эхийн "А" хувилбарт "tolong", "В" хувилбарт "tong" гэж байна. Мөн "toibutoi" (толботой) гэсэн үгийн аман аялгууны хэлбэр ч байж мэднэ.

⁸⁷ Г.Г-ын эхэд "serdengki" гэж буй. А.Позднеевийн 1907 онд Санктпетербургт хэвлүүлсэн "Кальмыцкая хрестоматия" (Халимаг хэлний дээж бичиг)-т хэвлүүлсэн "хоšuuд noγon bātur ubaši tümeni tuurbiqsan dörbön oyiradiyin tüüke"-д "mongγoliyin ubaši xung taiyiji qāgi (qāniyigi Ш.Ч) oyiradiyin erēn sayin serdengke gedeq bātur ercisiyin manitu γatulyani köbödü ubaši xung taiyiyigi bariji qorōji:-" (22-37) [Монголын Убаши Хун Тайж хааныг Ойрдын эрийн сайн Сэрдэнхэ гэдэг баатар Эрчисийн Мааньт гаталганы хөвөөнд барьж хороожээ.] гэж бичсэн байна.

⁸⁸ Г.Г-ын эхэд "хадхуqsan" гэж буй.

⁸⁹ Г.Г-ын эхэд "morin" (moriγen) гэж буй.

⁹⁰ Г.Г-ын эхэд "dayiladaxu dayison" гэж буй.

⁹¹ Г.Г-ын эхэд "šülüsēn" гэж буй.

⁹² Г.Г-ын эхэд "noyod" гэж буй.

⁹³ Г.Г-ын эхэд "isala" гэж буй. Зүүлт тайлбарын 71-ийг үз.

⁹⁴ Г.Г-ын эхэд "tere cini" гэж буй.

⁹⁵ Г.Г-ын эхэд "irčin" гэж буй.

⁹⁶ Г.Г-ын эхэд "puγuyān" гэж байх бөгөөд Ц.Дамдинсүрэн гуай Галсан Гомбоевийг дагаж, "нутгаа" гэж буулгасан байна. Энд нийтлүүлэн буй Хернхүтийн эхэд "otoγon" гэж тов тод бичсэн байх ба бас хам сэдвийн утга учрыг нягталбаас "отог-отгоо" гэх нь зөв буй.

xara erdeqčini⁹⁷ eleken kebtei ilirči⁹⁸ xoyid isalbayin⁹⁹ sayin kā dörbün mingyan jaluuyān dayouluqsan dörbön mingyan jidān xadxaqsan dörbön mingyan morin¹⁰⁰ soyiji orkiqsan

[4a.] üküldekü dayisun boliy¹⁰¹ ügečekü¹⁰² jaluu boluu¹⁰¹ geji šüdēn xabirči šülüsēn jalgiyi suudaq noyoud töündü durun-tan¹⁰³ yambar bayinai gebe:- isala terečin yai ügei töüni čā ken bayidaq bi kele gebe: öröügēr¹⁰⁴ olon xoyin-du¹⁰⁵ dobtoloqsan [oyotor kökü čino kebtei (Үүнийг Г.Г-ын эхээс нөхөн оруулав)] {өнжин yayum-a idege ügei}¹⁰⁶ ölöngküdöqsen bürgüdüyin nidü yaruqsan¹⁰⁷ jöün yar xotoyoitu xara xula¹⁰⁸ jurγān mingyan küün tere kebēr bayidaq noyoud töündü

⁹⁷ "erdeqcin" (ertegcin) гэдэг нь нэгэн зүйл нумын нэр бөгөөд Я.Цэвэл гуай "Нумын хөвч нь хоёр гичирийн хооронд, тэвхэнд дэлдэхгүйгээр хийсэн нум" (9-885) гэж тайлбарлажээ. Ц.Норжингийн найруулсан *"Монгол хэлний толь"*-д "Хөвч нь тэвхэндээ дэлдэхгүйгээр хийсэн хумагар нум" (23-303) гэжээ. Үгийн гарлын хувьд "эртих, эртгэр" гэх мэт үгтэй язгуур нэг буй. Нумын нэрд эм хүйс завсан "-гчин" дагавар залгадаг ёс байсан бөгөөд "уртагчин нум" [Усны үхрийн эврийг тэвхэнд нь хүртэл хадсан нум (23-885)] гэх мэтээр тохиолддог. Ташрамд дурдахад, Галсан Гомбоев, С.А.Козин нар "erdeqcin" гэсэн нумын нэрийг "үхэр" гэж эндүүрч орчуулжээ.

⁹⁸ Г.Г-ын "В" хувилбарт "erēlji", "С" хувилбарт "erelji" гэж буй.

⁹⁹ Г.Г-ын эхэд "eselbēn" гэж буй. *"Хошууд ноён Баатар Увш түмний туурвисан дөрвөн Ойрдын түүх"*-д "yobuyan mergenteni köbüün eselbei: edeni köbüün sayin kā kemēkü uul albatān medeji bayiqsan" (22-37) гэж байх тул "Эсэлбэй" гэж бичих нь зөв бололтой.

¹⁰⁰ Тод бичгийн энэ эхийн галигт, уламжлалыг баримтлан, "удааны тэмдэг" буюу уртатгалын тэмдгийг галиглахдаа өмнөх эгшгийн дээр уртын зураас тавилаа. "morin" гэж галигласан нь "morγūen" гэсэн утга буй. Бусдыг үүгээр жишин үзнэ буй заа.

¹⁰¹ Г.Г-ын эхэд "boluu" гэж байх бөгөөд тод бичгийн хэлэнд "bolbo uu" байх ёстой.

¹⁰² Г.Г-ын эхэд "ügesekü" гэж буй. Энд гарах "üküldekü dayisun boluu ügesekü jaluu boluu" гэдгийг Ц.Дамдинсүрэн гуай "Амь солих дайсан байна уу, ам зөрөх хүн байна уу" (6-8) гэж тайлбарласан нь утгын хувьд сайн нийцжээ.

¹⁰³ Г.Г-ын эхэд "durun-tan" гэж буй.

¹⁰⁴ "öröügēr" гэсэн нь "өглөөгүүр" гэсэн үг. Зүүлт тайлбар 55-ыг үз.

¹⁰⁵ Ойрд аялгуунд "хонь"-ийг "qoi" гэдэг бөгөөд түрэг төрлийн хэлэнд ч адил билээ.

¹⁰⁶ "Өнжин юм идээгүй" гэсэн энэ үгс тод бичгийн аль ч эхэд алга. Зөвхөн Ц.Дамдинсүрэн гуайн монгол бичиг болон кирилл үсгээр хэвлүүлсэн *"Убаши хун тайжийн тууж"*-д л тохиолдож байна. Туужийн энэ хэсгийг Ц.Дамдинсүрэн гуай тод бичгээс буулгахдаа:

"Сүрэг хонинд довтолсон

Сүрхий чонын дүртэй

Өнжин юм идээгүй

Өлөн бүргэдийн нүдтэй" (6-8) гэж толгой холбон, хэмнэл тааруулан, эхэд баригдалгүй шүлэглэсэн тул дээрх мөрийг нэмсэн бололтой.

¹⁰⁷ Г.Г-ын эхэд "yaruqsan" гэж буй. Харин "yaruqsan" нь зөв билээ.

¹⁰⁸ Г.Г-ын эхийн "А" хувилбарт "xulu", "В" хувилбарт "xula" гэж буй. Сурвалж бичгүүдэд тэмдэглэснээр "хага xula" гэх нь зөв болно.

duran-tan yambar bayinai: isla¹⁰⁹ tereči-ni ʔai ügei töünēsčini¹¹⁰ čā ken bayidaq
 bi kele gebe: narin ʔoliyin cken-du nariqan šarya moritai nayimin mingyan
 čereqtei utu¹¹¹ ʔoliyin belčir-tu oyiridiyin sayin temne¹¹² bātur tere kebēr bayidaq
 noyoud töündü duran-tan yambar bayinai gebe: isala¹¹³ terečin ʔai ügei: töüni
 čā ken bayidaq bi kele gebe: alaxui bulaxodān durtai arban bars
 doutē¹¹⁴ axoun¹¹⁵ tabun bariyin axa xošuud bayibuuyos¹¹⁶ xān tümün ʔuryān
 mingyan ʔaluryān dayouluqsan arban tabun termetei alaʔ bayibang-qān¹¹⁷ dundān
 dörbön oyiridiyin törö šajin xoyori-gi küüneji¹¹⁸ dörbön ʔüq-tü nadalai
 [4b.] adličaxu¹¹⁹ nigen činēn küün ügei buyija geji amān angyāji alixān¹²⁰
 sarwāji¹²¹ suunai gedeq beye mini muu күнē¹²² köböün bi nasu¹²³ mini dolōn
 nasutai dörbön oyiridiyigi ergeqsen ügei bi oyiridiyin köböün dörbön ʔüqtü bii

¹⁰⁹ Г.Г-ын эхэд энэ үг энэ хэсэгт алга. Өмнөх давтсан өгүүлэмжийн ёсоор уул нь байх ёстой. Үгийн тухайд зүүлт тайлбар 71-ийг үз.

¹¹⁰ Г.Г-ын эхэд "töüni" гэж буй.

¹¹¹ Ойрд аялгуунд "урт" гэхийг "ulu" (ут), буриад аялгуунд "ута" гэж хэлдэг.

¹¹² Г.Г-ын эхүүдийн "В" хувилбарт "tebene" гэж буй.

¹¹³ Зүүлт тайлбар 71-ийг үз.

¹¹⁴ Г.Г-ын эхэд "döütē" гэсэн нь эндүү бичлэг болно.

¹¹⁵ Г.Г-ын эхэд "axayin" гэж буй. Энэ хэсгийг уншихад "Ахын таван барын ах хошууд Байвгас хаан" гэхээр утга санаа, учир зүй нь сайн ухагдахгүй байна. Хамгийн гол нь эхний үг ах дүүгийн "ах" байж боломгүй.

Үүнийг тодруулахын тулд Байвгасын намтрыг ялимгүй нягтлахад, "Дөрвөн Ойрдын Хошууд аймгийн тэргүүлэгч Хани ноён Хонгорын Агай хатнаас төрсөн ахмад хүү нь Байвгас аж. Байвгасын эцэг Хани ноён Хонгор нас барахад, Байвгас бага байсан тул Хошууд аймаг ба Дөрвөн Ойрдын удирдах эрхийг түүний эх Агай хатан атгаж байв" (24-974) гэж түүхчид тодолжээ.

Түүхийн энэ мэдээ занги нь бидэнд дээрх үгийг зөв уншиж тайлах боломж олгож байгаа мэт. Бидний бодлоор, "Агайн (Агай хатны) таван барын ах" гэсэн үг ажээ. Тод бичгийн эхүүдэд "ayayin" гэдгийг "axayin" гэж бичсэн нь цэг тэмдгийн эндүү болсон бололтой.

¹¹⁶ Г.Г-ын эхэд "bayibaxus" гэж буй. Монгол түүхэн сурвалж бичгүүдэд "bayibayas" гэдэг билээ.

¹¹⁷ Г.Г-ын эхүүдийн "А" хувилбарт "bayibangxan", "В" хувилбарт "xas örgö" гэж буй. Г.И.Рамстедт Халимаг хэлний толь бичигтээ "bawngya- hof, palast (des fürsten) [baʔibangya<?čhin.]" (2-41) гэж орчуулан тайлжээ. Ван ноёдын орд өргөөг нэрлэдэг болохыг хэлээд, хятад гаралтай үг байж магадгүй гэж эргэлзсэн байна.

Халимаг-Орос толь бичигт "бээвнх [бэевеңхе] уст.(хуучирсан) кочевой княжеская юрта; арвн тавн термтэ бээвнх- дворец из пятнадцати решёток" (4-87) орчуулснаас үзвэл, хаад ноёдын нүүдлийн орд, том өргөө гэрийг хэлдэг ажээ.

¹¹⁸ "küüпexü" (хүүнэх) гэдэг нь ярилцах, хөөрөлдөх гэсэн утгатай ойрд аялгууны үг болохыг толь бичгүүдэд тодорхой тэмдэглэсэн байдаг. Хүүрнэх, хүүрнэлдэх гэдэгтэй язгуур нэг болох нь мэдээж билээ.

¹¹⁹ Г.Г-ын эхэд "adilcaxu" гэж буй.

¹²⁰ Г.Г-ын эхэд "alixān" гэж буй.

¹²¹ Г.Г-ын эхэд "sarbayiji" гэж буй.

¹²² Г.Г-ын эхэд "küüпeг" гэж буй.

¹²³ Г.Г-ын эхэд "nasun" гэж буй.

mini janggi ene gebe: tegēd uwaši xon tayiji tere köböügi abči yarči tuq tai¹²⁴
gebe: qoyor küün abči yartala noyoud-tu üge medöülnēbi gebe: dakiiji suulyād
jē islan¹²⁵ köböün ügēn kele gebe: köböün kelenē mongyoliyin sayin layixar xān
dörbön oyiridiyin sayin noyoud qoyor emēliyin aday šara xulusun-du¹²⁶ bayiri
kēd eltēd¹²⁷ xarixudān küüneldebe geji ese bilü: kele bariqsan küükön¹²⁸

¹²⁴ "tayiqu" хэмээх монгол бичгийн хэлний эртний үйл үгийн захирах хэлбэр "Тахих, тайх" гэж хоршин хэлдэг. "Хорин нэгт тайлбар толь"-д "Онгод тахиглаж тахихуйг таймуй хэмээмүй. Жич гэгээн язгуурт тахиглах, сүмд тахихуйг цөм таймуй хэмээмүй." (21-614) гэж тайлбарлажээ.

¹²⁵ Тайлбар зүүлт 71-ийг үз.

¹²⁶ Г.Г-ын эхэд "xuisun-du" гэж буй.

¹²⁷ Туужийн энэ хэсэгт гарч буй "bayiri kēd ellād" хэмээсэн нь "Хоёр тал тулалдан байлдаад (аль аль нь эс ялж), эвлэж найрамдаад" гэсэн утгатай болно. XV-XVII зууны монголын түүхэн сурвалж бичигт "bayiri" (байр) гэдэг үг нь дайн тулааны арга барилаар байлдаанд бэлтгэн бэхлэлт хийж, жагсах газрыг өгүүлсэн байдаг. "bayirilalduqu" (байрлалдах) хэмээвээс, эсрэг талын "bayiri" (байр)-ыг дайран эзлэхээр дайралдан байлдахыг хэлдэг байжээ.

Жишээ нь, "Хаадын үндсэн хураангуй алтан товч"-д "... Баруун түмэн нумын түлхүүр байр хийж ирвэй. Түүнд Даян хаан, ийм байрыг (ийм арга маягтай байлдах жагсаалыг Ш.Ч) чи мэдэм зээ гэж хар цэргийн ойрд Шигүсээс асуув. Шигүс хэлвэй: Ийм нумын түлхүүрт бух сэжүүр (бас нэгэн байлдах жагсаалын арга Ш.Ч) сайн билээ гэж жаран нэгэн бух сэжүүр байр хийв ..." (25-99) гэж байдаг. Мөн энэ сурвалж бичигт, Мачдухай цэцэн хатны байлдаан удирдсан тухай өгүүлэх хэсэгт "... Тас бүрд дээр довтолж, Дэгэдэнэ дээр байрлалдаж, тэнхэлгүй тасын талаа авч, дэгжүүлбэй, Зургаан түмэн улсаа ..." (25-91) гэж гардаг.

Г.И.Рамстедт "Халимаг хэлний толь"-доо "bāri (bayiri)- sčhlačhtfeld [тулааны талбар]; bāri köidexe (байр хийлдэх) eine sčhlačht liefern (einender) [эсрэгцэн тулалдах]" (2-40) гэж орчуулжээ. Халимаг-Орос толь бичигт "Бээр [бээрэ]- исг. (түүхэн) битва, бой, сражение; бээр бэрлдв- (байр байралдав Ш.Ч) произошло сражение; эгц хойр долан хонгт бээр бэрлдлхан (эгц хоёр долоон хонгт байр байрлалдалхан Ш.Ч.) Джангар битва шла в течение двух недель" (4-88) гэж тайлан орчуулсан байна.

"eltēd" (элтээх) гэдэг үгийг Г.И.Рамстедт "freundschaft sčhliessen (нөхөрлөх, найрамдах), frieden lieben (энхийг эрхэмлэх), friedlich sein (тайван амгалан байх)" (2-40) гэж орчуулсан байх бөгөөд бидний эх бичигт утга яг нийцэж буй.

"ellākū" (элтээх) хэмээсэн энэ үгийн язгуур нь "ei-il" бөгөөд Гүег (1206-1248) хааны тамганы бичээсийг өөрийн эрхгүй сануулж байна. Уг тамгын бичээс "il (ei) bulqa irgen-tür kürbesü büsirtüküi ayutuγai (эл булха иргэнд хүрвээс биширтүгэй айтугай)" гэж төгсдөг бөгөөд "эл- дотно, нөхөр, булха- харь, дайсан" гэсэн утгатай боллохыг судлаачид тодотсон бөгөөд Ойрд аялгууны "элтээх" гэдэг нь дунд үеийн монгол хэлний "bulqalduqu" (булхалдах) [дайсагналцах] хэмээсний эсрэг утгат үг ажээ.

Г.И.Рамстедт "Халимаг хэлний толь"-доо "el- frieden (энх), einträcht (эвтэй), bundesgenosse (хулбоотон), ničhtfeind (дайсан бус)" (2-118) гэж орчуулсан байдгийг бас дурдъя. Түүхч Х.Пэрлээ гуай "Засагт хан Лайхур 1577-1578 оны үед Ойрдтой Эмээлийн Шар Хулсанд эвийн хэлэлцээ хийсэн гэдэг" (26-96) хэмээн мэдээлсэн байдаг.

¹²⁸ Г.Г-ын эхэд "küügēn" гэж буй. Тод бичгийн зөв бичлэгээр бол "küüniyēn" байх ёстой.

kelöülē bayiji aladaq¹²⁹ bolji gemari¹³⁰ kele tasurji хоѳорьо геји андаяр¹³¹
aldaba геји есе билү: кеѳқсен сайин үгән мартаји [кеқсен сайин андаярән мартаји
(Үүнийг Г.Г-ын эхээс нөхөн оруулав)] namayigi yuundu үкүүлнэ¹³² та насун
mini dolōn nasutai muu күүнэ көбөөн билэби: амийн¹³³ мини хайрилуқтун¹³⁴
poyoud гебе: uwaši хон тайји төүн-дү хариу жарлиқ есе болји basa көбөөги хойор
күүн абѳи ыртала

[5a.] oyiridiyin janggi medöülnebi гебе: kele көбөөн гебе: alaxu boluxodu¹³⁵
durutai¹³⁶ arban baras doutei axoun¹³⁷ tabun bariyin axa хошүд байыаѳос¹³⁸ хән
kelenē¹³⁹ билē -:- uwaši хон тайји-ын харѳигинагийини¹⁴⁰ derlüülji хара ѳусуни¹⁴¹
asayoji¹⁴² хара тугийини хамугийин хәлүаду¹⁴³ хухуѳији оркід хайрилдақ¹⁴⁴ дара

¹²⁹ Г.Г-ын эхэд "aldaq" гэж байх бөгөөд "aladaq" гэсэн Хернхүтийн эхийн бичлэг зөв болно.

¹³⁰ Г.Г-ын эхэд "gemni" гэж буй. "kemene inü → kemēn ni → gemēn ni → gem ni → gemni" гэсэн үе шатыг дамжин хувьсч улирч ирсэн бололтой.

¹³¹ Г.Г-ын эхэд "andayārdaba" гэж буй. "Андгай тангараг" гэсэн үгийн эртний нэгэн хэлбэр нь "andayār" болно. Дунд үеийн монгол хэлний дурсгал болох "Мукаддимат-Ал-Адаб" тольд "'andayār- клятва; "andayārdaba tūnlē"- связался с ним взаимной клятвой (Түүнтэй андгай тангараг барилдав)" (27-102,103) гэж тэмдэглэсэн байдаг. Дээрх жишээтэй холбон нэгэн зүйлийг нэмэн дурдахад, дунд үеийн монгол хэлний өрнөт аялгууны онцлогийг хадгалсан гол дурсгал бол "Мукаддимат-Ал-Адаб" болно.

¹³² Г.Г-ын эхэд "üküülenē" гэж буй.

¹³³ Г.Г-ын эхэд "amiy" гэж буй.

¹³⁴ Г.Г-ын эхэд "хайралақтун" гэж буй. Энэ нь бичгийн хэлний хэлбэр болно.

¹³⁵ Г.Г-ын эхүүдийн "А" хувилбарт "bulaxu", "В" хувилбарт "bulāxu" гэж буй. Хам сэдвийн утгаас нь үзвэл, "В" хувилбарын "bulāxu" (булаах) гэсэн бичлэг зөв буй заа. Ц.Дамдинсүрэн гуай ч "булаах" гэж буулгасан байдаг.

¹³⁶ Г.Г-ын эхэд "durtaī" гэж буй. Бичгийн хэлний зөв бичлэг нь "durataī" байх ёстой.

¹³⁷ Г.Г-ын эхэд "ахауин" гэж буй.

¹³⁸ Г.Г-ын эхэд "хошүд байыаѳос" гэж буй.

¹³⁹ Г.Г-ын эхэд "kelenē" гэсэн үгийн хойно "gedeq" гэж буй.

¹⁴⁰ Г.Г-ын эхэд "харсауауигийини" гэж буй. Сээр нурууны хоорондох ясыг "харцага" гэдэг бөгөөд Ц.Дамдинсүрэн гуай "харцага яс" гэж буулгасан байх боловч мөн эсэхэд эргэлзэж байна. Г.Г-ын эхэд "харцгай" гэсэн нь "харцага"-тай ойр сонсогдох боловч Хернхүтийн эхэд "харсигинаг" гэж байгаа билээ.

Г.И.Рамстедт "Халимаг хэлний толь"-доо "xartsyanag (xartsxanay)- after (бөгс, хошног), steiss (хондлой), syn.(синоним) хошгоног, онай, өжгөнөг, цөгц махан, бөгс бие, малай махан" (2-170) гэж орчуулан тайлбарлажээ. Ж.Крюгерийн "Ойрад Монгол үгийн түүвэр толь"-д "хагсагинаг- rump (ууц), built (бөгс)" (31-267) гэж орчуулжээ.

Үүнээс мөшгин бодоход, "харчинагийг нь дэрлүүлэх" гэсэн нь "хонго бөгсийг нь юм уу хош гэдсийг нь дэрлүүлэх" гэсэн үг бололтой.

¹⁴¹ Г.Г-ын эхэд "cusuyini" гэж буй.

¹⁴² Г.Г-ын эхэд "asxogulji" гэж буй.

¹⁴³ Ойрд аялгуунд замыг "хәлүа" (хаалга) гэдэг. Энд өгүүлж буй хэсэг нь "Убаши хун тайжийн харчигинагийг нь (хонго, хошийг нь) дэрлүүлж, хар цусыг нь

xatulayini¹⁴⁵ niyileji¹⁴⁶ čusun ulān xačariyini önesji¹⁴⁷ čuudai¹⁴⁸ čayān beyeyini teberči [artai čayān arbingduni arban xara sawarān kirkūji]¹⁴⁹ budmal ulān xalxaduni¹⁵⁰ buyan-tu sayixan saxalān kurgūji buyan kišiq xoyoriyini ejelebe geji erte bembedēsü¹⁵¹ abuqсан ginta¹⁵² bolod¹⁵³ üldēren¹⁵⁴ xatāji keqsen xara bolod

асгаруулж, хар тугийг нь хамгийн хаалгад (олны зам дээр Ш.Ч) хугачиж орхиод ...” гэсэн утгатай ажээ.

¹⁴⁴ Г.Г-ын эхэд “xayiraldaq” гэж буй.

¹⁴⁵ Г.Г-ын эхэд “xatulayini” гэж буй. Монгол бичгийн хэлээр бол “qatun – luy-a anu” гэсэн үг.

¹⁴⁶ Г.Г-ын эхэд “neyiji” гэж буй.

¹⁴⁷ Г.Г-ын эхэд “ünesji” гэж буй. “ünüsci” гэж бичих нь тод бичгийн хэлний дүрэмд нийцнэ. Гэхдээ энэ тууж нь аман аялгууг ихээхэн тусгасан ажээ.

¹⁴⁸ Энэ үг тод бичгийн эхүүдэд “cuudai” (цуудай) гэж байх бөгөөд Ц.Дамдинсүрэн гуай “цуутай” гэж буулгажээ. Уг үг нь цав цагаан гэсэн утгатай ойрд аялгууны үг болох нь толь бичгүүд үзэхэд тодорхой байна. Халимаг-Орос тольд “цууда-белый; цууда цаһан бэрэчүд, цусан улан күүкд (цуудай цагаан бэрчүүд, цусан улаан хүүхнүүд)- фольк.(аман зохиол) белолицые молодицы, румянолицые девушки (цав цагаан царайтай залуу бүсгүйчүүд, ув улаан хацартай охид хүүхнүүд)” (4-642) гэж байна. Г.И.Рамстедт “Халимаг хэлний толь”-доо “tsüdä- weisser kaliko (цагаан гөлөнгөр буюу гөлгөр болгон цардсан цагаан бөс)” (2-435) гэж орчуулжээ.

Дээрх жишээ баримтад түшвэл, “... cusun ulān xačariyini önesji: cuudai čayān beyeyini teberči ...” гэсэн нь “... цусан улаан хацрыг нь үнэсч, цав (цуудай) цагаан биеийг нь тэвэрч ...” гэсэн үгс ажээ.

¹⁴⁹ “artai čayān arbingduni arban xara sawarān kirkūji” [артай (нугалаастай) цагаан арвинд нь (харвинд нь) арван хар савраа хүргэж] гэсэн энэ хэсэг Г.Г-ын эхүүдэд байхгүй байна.

¹⁵⁰ “халх” гэж “хацар”-тай адил утгатай. “Зүүдлээд сэрсэн нь” гэдэг Дөрвөд ардын дуунд:

“Хоо (ухаа) толгойн өвөрт

Хоносон болж л зүүдлээд

Хоо (ухаа) ягаан халхыг нь (хацрыг нь)

Үмссэн (үнэссэн) болж л зүүдлээд

Өрүүнэ (өглөө нь) босоод халиахад (харахад)

Ердөөн ганцаараа байж л” (28-315) гэж байх жишээтэй.

¹⁵¹ Тус туужийн одоо мэдэгдэж байгаа аль ч эхэд “bembedēsü” гэжээ. Ямар утгатай үг болохыг тодолж чадсангүй. Тун үнэмшил багатай нэгэн таамаг хэлэхэд, “Гэрийн ерөөл”-д:

“Балбын дархан балбаж хийсэн

Хачийн дархан хадаж хийсэн” гэж гардаг. Энэ нь эрт цагаас, Балба (Непал), Хач (Кашмир)-ын дархчуулын хийсэн эд зүйл нь Дундад Азиар дамжин, Монголчуудын дунд түгэн дэлгэрч их алдартай болсныг гэрчилж байгаа хэрэг. Туужийн энэ хэсгийн “bembedēsü” гэх үг нь “Балбын дархнаас” гэсэн үг сунжран хэлэгдсээр ийм болсон байж мэдэх юм.

Ж.Цэвээн (Ц.Жамсранов) гуай ХХ зууны эхээр Ордос нутгаас олж авсан, одоо Санктпетербургт хадгалагдаж байгаа “Хонжин дэвтэр” (Ёслолын хэргийг эрхэлсэн түшмэлийн дэвтэр)- т тайлбарлан бичихдээ “Чулуу цавчих даах хурц илдний тайлбар нь :

Баруун зүгт Балаху (balaqu) нэрт дархан гэгч наян төмрөөр найруулан зодож, нарандаа барьж хайлаад, зуун жин төмрийг зэруулан зодож, сарны гэрэлд царцаагаад, бат их дешин дээрээ тавьж, биндэрьяа нэрт сүхээр зодож, цуд [цул цэвэр (12-2279)] болд нэрт илд тэр зүгийн өмнө өргөн их өөхөн хадыг халтиралгүй даах тул хаан ба харц хамтадахуйн тул өлзийт сайхан өдөр эд бэлэг болгон авчирав" (5-90) гэж бичжээ.

Судлаачид XIV, XV зууны үеийнх гэж гол төлөв үздэг энэ сонин номд бидний сонирхож буй илдний тухай, ялангуяа "Баруун зүгийн Балаху нэрт дархан" бээр цул цэвэр болд илд хийдэг байсан тухай өгүүлсэн нь эш татан холбоход хүргэлээ.

¹⁵² "ginla" гэдэг үгийг Сэцэнцогт "Монгол үгсийн язгуурын толь"-доо "ginte-хурц иртэй хутга, голдуу үс хусах багажийг хэлдэг" (12-1261) гээд "Увш Хун Тайжийн тууж"-ийн яг энэ хэсгийг жишээ болгожээ.

Эртний түрэг хэлний тольд үзвэл, "qin ножны (хутганы хуй), "qilis меч (сэлэм)" (13-442,444) гэсэн ойролцоо язгуур бүхий үгс бий. Орос хэлний "кинжал" гэдгийг Орос хэлний үгийн гарлын тольд үзвэл, "кинжал- вероятно, является заимствованием конца XVIIв. из тюркск.яз. [ср. (адилтга) кумыкск, кынджал] Первоисточник-арабск.яз." (29-194) гэж бичжээ. Энд тайлбарлахдаа, XVII зууны үед түрэгээс авсан араб гаралтай үг гэсэн байх бөгөөд сайн "кинжал" хутгыг "ginla-ginte" болдоор хийдэг байсан буй заа. Дээр эш татсан үгсийн язгуур нэг болов уу.

Гянт болд гэдэг нь галд тэсвэртэй, дээд зэргийн ган төмрийг хэлдэг бөгөөд саяхан гарсан Орос-Монгол том толь бичигт "гянт- (gintu) гянт болд асбест" (30-486) гэж орчуулжээ. "Asbestos" гэсэн грек гаралтай "асбест" гэдэг үг нь галд болон хүчилд тэсвэртэй холимог эрдсийг нэрлэдэг ажээ.

Ц.Дамдинсүрэн гуай нарын "Орос-Монгол толь"-д "асбест- шөрмөсөн чулуу" (8-17) гэж орчуулжээ. Энэ мэтээс үзэхэд, "гянт болд" гэдгийг "асбест" гэж орчуулсан орос орчуулга нь таарсан эсэхийг судлаачид тунгаах буй заа.

¹⁵³ "bolod" гэдэг нь перс гаралтай "pulad" гэсэн үг бөгөөд "сайтар боловсруулж, холимоггүй болгосон маш хатан төмөрлөг, ган ч гэдэг" (12-759) ажээ.

¹⁵⁴ "üldü", "hildü" гэсэн хэлбэрээр дундад үеийн монгол хэлний дурсгалуудад тохиолддог энэ үгийг Ойрд, Ордос аялгуунд "үлд" гэж хэлдэг. Зарим судлаачид төвд хэлний "ral-ᠭᠢ" (ралди) гэдэг үгээс гаралтай гэжээ. "ралди" гэдэг нь "хагалах, огтлох хутга" гэсэн утгатай төвд үг. Энэ нь зөвхөн төвдийн нэгэн аялгын дуудлагын адил төсөө төдий л юм. Иймээс төвд үг гэж үзэх үндэсгүй юм.

"МНТ"-ны 106-р зүйлд: "oroq qurdun-ıyan unuba bi hüdösütü quıyag-ıyan emüsba bi onggitü üldü-be'en barıba bi onotu sumu-ıyan onolaba bi" [Орог хурднаа унав би. Үдээст хуягаа өмсөө би. Онгит илдээ барив би. Онот сумаа онилов би.] (10-43) хэмээн гарах бөгөөд бас "... üldüs aqsaju ..." [илд арсаж] (10-53); "... üldü-ör qangqas sabciju ..." [илдээр хага цавчиж] (10-55); "... üldü jida-tur daduqsan irgen ..." [илд жадад дадсан иргэн] (10-81); "... temür öreten üldü mina'atan ..." [төмөр голтон (зүрхтэн), илд ташууртан] (10-104); "... üldütü ere-yi hüldejü..." [илдэт эрийг үлдэж (хөөж)] (10-104) гэсэн ийм холбоо үгст таван удаа тохиолдож байна.

"Мукадиматт-Ал-Адаб" тольд "hildü (илд); hildüyi quidu dūrūbe (илдийг хуйд дүрэв); hildüyin ban'ör (илдийн бариул)" (27-184,185) гэх мэтээр тохиолдож байна. Бидний нийтлүүлж буй эхийн "З-а" талд "ildü" гэсэн хэлбэрээр бас бичсэн буй.

Бидний бодлоор энэ үгийн язгуур нь алттай хэлний "ki-" язгуурт үгээс авианы хувьслаар улирч ирсэн үг юм. "kiduy-a" (хутга)-тай ч язгуур нэг бөгөөд үгийн эхний "k" авиа нь суларч гээгдсэн бололтой.

"илд"-ийг түрэг хэлний "qilis"-тэй харьцуулах нь зөв билээ. Чухам юуг нэрлэдэг тухайд бол "Сэлэмнээс өргөн бөгөөд охор, нэг талдаа иртэй, хуйлж зүүдэг

tulyān yal yartula čibčiba gedeq tere keleqseni ta sanji ülü bayinu ta-¹⁵⁵ tegēd köböügi abči yarād tuq tayiba:- mongyoliyin tuq yörökü küün ese yarči: tugiyin ejen bi bolbo bi yörökünö yamaruu gebe: köböün sayitur yörö:¹⁵⁶ bi-čigi¹⁵⁷ yörösü ta-čigi¹⁵⁸ sonosuqtun¹⁵⁹ xayirxan dayiči tenggeri ideji uuqtun:¹⁶⁰ uwaši xon tayijiyin xara čusuni asaxoriba¹⁶¹ xarčagina-

[Sb.] giyini¹⁶² derlölbe xara tugiyini¹⁶³ xamugiyin xālyadu¹⁶⁴ xuyuran xočorba: qayirildaq dara xatūni¹⁶⁵ xamugiyin ejen bayibuyus aba: utu xara tugiyini oyiridiyin köldü xuyoran xočuruba:¹⁶⁶ oroī-yin¹⁶⁷ oroq šarqal morini ulān torγun čulbuuran unjūlād yabuqseni oyiridiyin¹⁶⁸ nige köböün jiloyāsuni jidār ölgūd¹⁶⁹ joqsoxu boltuyai bačuda¹⁷⁰ balbaritalān čičiüleqtün ködödü köürmeq¹⁷¹ boltulān čičiüleqtün emēliyin olon¹⁷² dolōdayidu elki¹⁷³ bōrōn abuqtun qadān¹⁷⁴ ekendü xayibuuruulan¹⁷⁵ čičiüleqtün buluqtuyin γoldu budaxān (budayān Г.Г) sandān čičiüleqtün: buyan kišiq xoyoriyton oyiridiyin köböün abxu boltuyai:- uuladu kürēd ongxu bayiqtun¹⁷⁶ köböüni amini tegēd yarba¹⁷⁷:- tegēd mongyoliyin čereq

нэгэн зүйлийн цэргийн зэвсэг" (12-287)-ийг хэлдэг ажээ. Монгол бичгийн дурсгалуудад "ildü", "öldü", "yöldü" гэж янз янзаар бичсэн байдаг.

¹⁵⁵ Г.Г-ын эхэд "bayin ta gebe" гэж буй.

¹⁵⁶ Г.Г-ын эхэд "yörö" гэсэн үгийн хойно "gebe" гэж буй.

¹⁵⁷ Г.Г-ын эхэд "bi-čigi sayitur" гэж буй. Монгол бичгийн хэлний "ci" сул үгтэй адил утгатай "čigi" гэсэн үгийг хамт, саланги янз янзаар бичсэн байдаг.

¹⁵⁸ Г.Г-ын эхэд "ta čigi" гэсэн үгийн хойно "sayitur" гэж буй.

¹⁵⁹ Г.Г-ын эхэд "sonosoqtun" гэсний хойно "gebe" гэж буй.

¹⁶⁰ Г.Г-ын эхэд "uuqtun" гэсэн үгийн хойно "gēd" гэж буй.

¹⁶¹ Г.Г-ын эхэд "cusuyini asxuruulbai" гэж буй.

¹⁶² Г.Г-ын эхэд "xarčayanaγiyini" гэж буй.

¹⁶³ Г.Г-ын эхэд "luqni" (туг нь) гэж буй. Энэ үгийн хэлбэр нь хам сэдвийн утгандаа нийцэж байна.

¹⁶⁴ Тайлбар зүүлт 143-ыг үз.

¹⁶⁵ Г.Г-ын эхэд "xayiraldaq dara xatuni" гэж буй.

¹⁶⁶ Г.Г-ын эхэд "xočorba" гэж буй.

¹⁶⁷ Г.Г-ын эхэд "oroγiyin" гэж буй.

¹⁶⁸ Г.Г-ын эхэд "oyiridiyin" гэжээ. Гэвч мөн эхэд "oyiridiyin" гэж ихэнхдээ бичсэн байна.

¹⁶⁹ Г.Г-ын "A" эхэд "ölgēd", "B" эхэд "örgūd" гэж буй.

¹⁷⁰ Г.Г-ын эхэд "bači-da" гэж буй.

¹⁷¹ Г.Г-ын "A" эхэд "kōmköröūsōn", "B" эхэд "kōmōrsen" гэжээ. Г.Г-ын эхийг баримталбал, "хөмрөх" гэсэн үгээс гаралтай болох нь ил тул Ц.Дамдинсүрэн гуай "хөмөртөл" гэж буулгасан нь утга таарч буй. Харин энд толилуулан буй Хернхүтийн эхийг баривал, "хүүрмэг" (үйрмэг) гэж унших ёстой. "Хүүрмэг болтлоо" гэхэд утга бас таарна.

¹⁷² "olon" гэдэг нь "гатлага" гэдэгтэй адил утгатай бөгөөд монгол бичигт "olun" гэдэг. Энд Эмил голын Долоодой нэрт гатлага гармыг хэлсэн бололтой. Г.И.Рамстедт Өөлд аман аялгуунд "олом, гарам" гэж хэлдгийг тэмдэглэжээ.

¹⁷³ Г.Г-ын эхэд "elke" гэж буй.

¹⁷⁴ Г.Г-ын эхэд "xadiyin" гэж буй.

¹⁷⁵ Г.Г-ын "A" эхэд "xayikaroulan", "B" эхэд "qamqartala" гэж буй.

¹⁷⁶ Г.Г-ын эхэд "bayiqtan gēd" гэж буй.

niyidēr tumuqči¹⁷⁸ tere köböüni ügedü ünün¹⁷⁹ xudul bolba-čigi muu irör¹⁸⁰ bolba geji ene yuu bolba geji yeke jobuji¹⁸¹ tegebe-čigi mongyoliyin sayin uwasi xon tayiji dayināsu juluji xaribe gekü nere sonosoxoyin oron-du sayiduxu muudaxu bolba-čigi

[6a.] yabun bayiji kirēn medeye gēd yabuba:- irčūs yolai¹⁸² yatulād emēliyin adaq šara xulusār yabūd bači ginjiliyin ekēr¹⁸³ tōündü nayimin tümün¹⁸⁴ čereq buuji bayiyād arban yurbatayāsu¹⁸⁵ nārān yučin dolōtoi күртүлән dayinai köldü ülü endöuredeq bāxān bolbusayini-gi¹⁸⁶ (bolbusan-nayigi гэж хажууд нь зассан) način xaltar moritai-gi dörbön oyirid-tu xoyor xonoyōr boljād¹⁸⁷ turšuuл talbiba: uwaši xon tayiji¹⁸⁸ xotun čayān temegēn ökūülēd jaluusān ire gēd maqtuji suuji öqbö: jē usundu orodaq serkēn eber¹⁸⁹ boloqsan: uulyon-du orodaq ulāni mini čiken boluqsan jaluus mini sonosoqtun xara möretē¹⁹⁰ köböüni xarāl tere biši-yu

¹⁷⁷ Г.Г-ын "А" эхэд "yarbai", "В" эхэд "tasurabai" гэж буй.

¹⁷⁸ "tumuqči" (тумагч) хэмээх ойрд аялгууны энэ үгийн "өлгөгдөгч" гэж Ц.Дамдинсүрэн гуай хвалтад тайлбар хийжээ.

Г.И.Рамстедт *"Халимаг хэлний толь"*-доо "tumāxa (тумах)- auf einen pfahl spriessen (den feind od. das opfertier, Pozdn.203)" (2-410) гэж тайлбарлажээ. Г.И.Рамстедт Позднеевээс эш татаж, дайсан буюу тахил тайлгад хэрэглэх амьтныг шонд өлгөхийг хэлдэг болохыг заажээ. Халимаг-Орос тольд үзвэл, "тумх [тумхъ] уст (хуучирсан) сажать на кол (гадасан дээр суулгах-шорны үзүүрт өлгөх) напр. (жишээ нь) врага или или жертвенное животное" (4-517) гэж орчуулсан нь өмнөх тайлбартай адил аж.

Эдгээрээс үзвэл, цэрэг дайны туг тахих тайхаар, шор буюу шонд өлгөгдөх учиртай болсон хүн амьтныг "тумагч" гэж тодотгон хэлдэг байжээ.

¹⁷⁹ Г.Г-ын эхэд "ünel" гэж буй.

¹⁸⁰ Г.Г-ын эхэд "yöör" гэж буй. Хөрнхүтийн эхийн "igō" гэсэн бичлэгт, уг үгийн эртний хэлбэр тухайлбал "igüger" гэсэн монгол бичгийн хэлний байдал тод харагдаж байна. "МНТ"-нд "hirü'er" (10-113) гэж галигласан байдаг. Энэ үг "hirüger→ hirü'er→ irü'er→ igöör→ yöör" гэх мэтээр хувиран ирсэн ажээ.

Энэ үгийг тайлбарлах ташрамд дурдахад, "ёр" гэсэн үг үүнтэй язгуур нэг болохыг Сэцэнцогт (12-310) заан тэмдэглэжээ. "Ёр" гэдэг үгийг монгол бичгээр "iru-a-irw-a" гэж бичдэг бөгөөд эртний түрэгээр мөн "irü" (13-212) гэж хэлдэг. Бас "irü belgä-признак, знак, примета" (13-212) [ёр бэлгэ] гэж монголтой адилаар хэлдэг байжээ. "Ерөөл" гэхийг манжаар "irüge", "irügemui" (ерөөмүй) гэсэн монгол үгийг "irümbi" гэдэг байна. Ийн үзвэл, "irü-, hirü-, irü-" гэсэн язгуур нь Алтай хэлний үг болох ажээ.

¹⁸¹ Г.Г-ын эхэд "yekedü jobabai" гэж буй.

¹⁸² Г.Г-ын эхэд "yoliyigi" гэж буй.

¹⁸³ Г.Г-ын эхэд "ekēr" гэсэн үгийн хойно "oroji" гэсэн үг буй.

¹⁸⁴ Г.Г-ын эхэд "tūmen" гэж буй.

¹⁸⁵ Г.Г-ын эхэд "yurbatayiyāsu" гэж буй.

¹⁸⁶ Г.Г-ын эхэд "bāxan bolbasaniyigi" гэж буй.

¹⁸⁷ Г.Г-ын "А" эхэд "bolōd", "В" эхэд "boljōd" гэж буй.

¹⁸⁸ Г.Г-ын эхэд "tayiji" гэсэн үгийн хойно "qoš aciqsan" гэж буй. "qoš" гэдэг үгийн тухай тайлбар зүүлт 65-ыг үз.

¹⁸⁹ Г.Г-ын эхэд "öbör" гэж буй. "eber" нь зөв билээ.

¹⁹⁰ Г.Г-ын эхэд "möretei" гэж буй.

xari dörbön oyiridiyin janggi tere biši-yu xara külesēn¹⁹¹ bū xayirilaqtun jaluus¹⁹² noyon-dān medöülji: kejē besü asaxoriba čusun nigen kebtebe yasun nigen: noyodiyin ömnö öülēn nökü¹⁹³ ügei bida geji kürjicneqsēr xarči [yarči = Г.Г.] odbo: tegēd bāxān bolbusun¹⁹⁴ irēd dörbön oyiridiyin janggiyini [6b.] uwaši xon tayiji-du medöülji dörbön oyirid jarāgiyin üsün bolji körögiyin šüden¹⁹⁵ bolji dörbölji tekelčüq (tekečüq гэж хажууд нь зассан) bayinai maniygi¹⁹⁶ āšin¹⁹⁷ gēd saqlaji¹⁹⁸ bayixoyin čigi medeküü¹⁹⁹ biši bi [yerü saqtai bayidagiyini- čigi medekü biši bi Г.Г.]-²⁰⁰ oyiridiyin janggi ene gebe:- uwaši xon tayiji jarliq bolbo: dörbön tümür²⁰¹ uulyoči kēd²⁰² dörbön tümür eke kēd oyirid uruu yabuxonan yāxu biyija genēji gebe:- bāxan bolbusun medöülbe dörbön oyirid-lai bayiridlad²⁰³ öröün julxona kele yarxu bida: asuyon julxona kele tasurxu bida geqsen-dü uwaši xon tayiji čuxuldād ünen xudal bolbo-čigi xayiran jaluus-suni²⁰⁴ mini jürke xatāji xatuuyār kelbeči geji ömnöki köböüni yosör jasa

¹⁹¹ Г.Г- эхэд "kölsön" гэж буй.

¹⁹² Г.Г-ын эхэд "jaluus" гэдгийн хойно "gebe" гэж буй.

¹⁹³ "öülēn nökü ügei" (үйлээ нөөхгүй) гэсэн нь хэргээ нуухгүй, хүчээ хайрлахгүй гэсэн утгатай бололтой.

¹⁹⁴ Г.Г-ын эхэд "bāxan bolbasan" гэж буй.

¹⁹⁵ Г.Г-ын эхэд "šüdü" гэж буй.

¹⁹⁶ Г.Г-ын эхэд "maniyigi" гэж буй.

¹⁹⁷ Г.И.Рамстедт Халимаг хэлний тольдоо "āšā- sich nähern (дөхөх), nahe kommen (ойртох), heranrücken (ойртуулах), anlangen (хүрч ирэх)" (2-21) гэж орчуулжээ. Халимаг-Орос толинд "ааш [аашхъ] приближаться; подходить близко; придвигаться" (4-19) гэж орчуулсан нь мөн адил байна.

Эртний болон дунд үеийн монгол хэлэнд идэвхтэй хэрэглэгдэж байсан "ayisqu~ayisuqu" (айсах) гэдэг үг бөгөөд Халимаг хэлэнд "ааших" хэмээн идэвхтэй хэрэглэгдэж байна. Харин орчин цагийн халх аялгуунд бол "айсуй" гэсэн хэл зүйн үгийн хэлбэрт л үлджээ.

¹⁹⁸ "saqlaxu" гэдэг үг нь урьдаас болгоомжлох, сэргэмжтэй байх, сэжиг ажиг авах гэсэн утгатай үг болохыг толь бичгүүдэд тодорхой тэмдэглэсэн байна.

Түрэг төрлийн хэлэнд "sak-, sakla-" гэсэн хэлбэрээр, мөн адил утгатай тохиолдоно. Сэцэнцогт "Монгол үгсийн язгуурын толь"-доо "say- (саг-) – сэрэмж, хичээмж, болгоомж; sayla- (сагла -) – сэргийлэх, болгоомжлох" (12-1450) гэж тайлбарлаад, цагдах, цагдаа гэдэг үгтэй нэг язгууртай "s", "c" авиа сэлгэснээс үүссэн гэж үзжээ. Халимаг-Орос толинд "сарсхр тавгта, сэг ишқдлтэ [сарсгар тавагтай, сэг гишгэгдэлтэй] загадка; имеет разветвлённую лапу, осторожно походу (мис кошка)" (4-435) гэсэн оньсогоор жишээ болгожээ.

¹⁹⁹ Г.Г-ын эхэд "bayixoyini-cigi medekü" гэж буй.

²⁰⁰ Г.Г-ын эхэд "biši bi" гэдгийн хойно "yerü saqtai bayidagiyini-cigi medekü biši bi" гэж буй

²⁰¹ Г.Г-ын эхэд "tümür" гэж буй.

²⁰² "kēd" гэдэг нь "хийгээд" гэсэн үгийн аман аялгууны дуудлага билээ.

Тайлбар зүүлт 56-г үз.

²⁰³ Г.Г-ын эхэд "bayirildād" гэж буй. Тайлбар зүүлт 127-г үз. Монгол бичгээр бол "bayirilduyad" байх ёстой.

²⁰⁴ Г.Г-ын эхэд "jaluusiyini" гэж буй.

gebe: bāxan bolbusun načın xaltar morērūn²⁰⁵ arayıxan geji julaji yarba: tegēd uwaši xon tayiji urun xāni majiq²⁰⁶ xoyita nerēn tölö yabuxougi jöbsökēd²⁰⁷ uulıyan öröün

[7a.] talbiyc geji bayiyād uwaši xon tayiji uulıyan uurālan²⁰⁸ talbiji urun xāni sayın majiq töündüni ötöji (ödči гэж зассан байна)²⁰⁹ xon tayiji-du medöülji: gertēsün yarči yabuqsanāsun nāran olon buruu keji yabuuči odo²¹⁰ ene buruugiy čini dāxu biši bi: kele bariqsan köböün²¹¹ kelöülē bayiji üküüleqsen nige muu yoro čini ene: nayimın költē zandan šerēgi-neyin²¹² köliyiini xoyučiiji orkibači xoyor muu yoro čini ene: xoton čayān temegēn²¹³ tüleşēn idöüleqsen²¹⁴ yurban muu yoro čini ene: odö nadāsu dayini mal xaramnād uulıu uurālan²¹⁵ talbiqsan dörbön muu yoro čini ene: kötöči yabuqsan nöküdesün dai²¹⁶ xaramnaqsan učirčini xara noxōn čusu xaramnaqsan ilıyal ügei gedeq bi²¹⁷ xariyiini (xarini гэж хажууд нь зассан)²¹⁸ bi gēd tümün tabun mingıyan uulıyačiyın²¹⁹ abād xariba:- xon tayiji dörbön oyiridiyigi jorin yabuba: uran (urun гэж хажууд нь зассан) xāni majiq küüni dörböd moritai xoyor mingıyan küü²²⁰ talbiji bāxan bolbusun-du jakaji börrör kürči dobtolöd keltegegēr²²¹

[7b.] xariji ire kele bariji dörbön oyirid-tu janggi oruul: nutuq mini xangıyayın xara buluqtu²²² xari dörbön oyirid tani üjeye geji irilē bida: odöi (odö гэж хажууд нь зассан.) dörbön tümün küün bi xariba bi: nātan uwaši xon tayiji čubuqsun

²⁰⁵ Г.Г.-ын эхэд "morēr" гэж буй.

²⁰⁶ Г.Г.-ын эхэд "majiq" гэдгийн хойно "qoyor" гэж буй.

²⁰⁷ Г.Г.-ын эхэд "yabuxuyigi jöbsögöd" гэж буй.

²⁰⁸ Г.Г.-ын эхэд "uulıyan urālān" гэж буй. Монгол бичгийн хэлэнд "qayuly-a; ayuly-a; uuly-a" гэж адил бус бичсэн байдаг. "uuly-a" гэж цэргийн туршуул анги, сорилгын хошууч хэсгийг нэрлэдэг байжээ.

²⁰⁹ Г.Г.-ын "A" эхэд "ölöji", "B" эхэд "öyilöji" гэж буй. "Өөлөх" нь хам сэдвийн утгад тохирч байна. Халимаг-Орос толинд "өөлх [өөлхэ] чувствовать себя оскорблённым, обижаться" (4-420) гэж орчуулснаас үзвэл "гомдон өөнтөглөх" гэсэн утгатай ажээ.

²¹⁰ Г.Г.-ын эхэд "yabuji: odö" гэж буй.

²¹¹ Г.Г.-ын эхэд "küügēn" гэж буй.

²¹² Г.Г.-ын эхэд "širēgēn" гэж буй.

²¹³ Г.Г.-ын эхэд "temēgēren" гэж буй.

²¹⁴ "tüleşēn idöüleqsen" гэдгийг Ц.Дамдинсүрэн гуай "түлшний тайлгад идүүлсэн" гэж буулгасан байдаг. Эрт цагт үхэгсдийн хойноос шатаах тахилгын юмыг түлш гэж нэрлэдэг байжээ.

²¹⁵ Г.Г.-ын эхэд "urālān" гэж буй.

²¹⁶ Г.Г.-ын "A" эхэд "dai", "B" эхэд "dai-ni mal" гэж буй. "Дайны мал" гэсэн "B" хувилбар нь зөв буй заа.

²¹⁷ Г.Г.-ын эхэд "xaramnasanni la ilıyal ügei gedeq bii" гэж буй.

²¹⁸ Г.Г.-ын эхэд "xarinei" (харина) гэж буй.

²¹⁹ Г.Г.-ын эхэд "uulıyacın" (уулгачаан) гэж буй.

²²⁰ Г.Г.-ын "A" эхэд "küü", "B" эхэд "küi" гэж буй. "küün" гэж байх нь зөв буй заа.

²²¹ Г.Г.-ын эхэд "doblalād keltegegēr" гэж буй.

²²² Г.Г.-ын эхэд "buluqtu" гэсэн үгийн хойно "ge" гэж буй.

sürüq odbo töüni yāxān eberēn medeqtün geji kele oruul gād ilgēbe-:- majigiyin jakaqsār urālān kürēd utu küi²²³ olju abād aridān kele oruulji uwaši xon tayiji-yin uulyāci ökür xoi oljolöd joqsoji: tegēd dörbön oyiridiyin čereqni čuqluji irēd uwaši xon tayiji-gi gederegēn yaryul ügei urālān²²⁴ yabuulal ügei mōn töündüni buulyād yurbun xonoq dayilba:²²⁵ mongyoliyin čereq niyidēr muuduji²²⁶ irikülēren uwaši xon tayiji-yin xara tuqgiyini²²⁷ čirēd xayirildaḡ jaluus abād yarči yabutala oyiridiyin sayin sērdengki²²⁸ olon čeregēsü ončo orōd uwaši xon tayiji-du

[8a.] jida örgüküdān medöüleqsen ügeni jē noyōd jārtu xobčasunastun²²⁹ ömösji bilēbi dabsutu²³⁰ šüüsenēstün²³¹ yekede kürtülei bi-:- teqbe-čigi xari dörbön oyiridiyin nerēn²³² iölö baruun bōrödütün jida örgübēbi: noyōd tolyoi mini tere gēd čičiqsen.²³³ tegēd uwaši xon tayiji tere šarxadān čödö bolxoyin urida oroḡ šarxouliyigi (šarxalayigi гэж хажууд нь зассан.) talbiqtun nutuqtu janggi oruulturyai.²³⁴ čini ayixu ügei xaraji ta²³⁵ ükebe gekü xayirin nerēn sanaji ničēdiyini²³⁶ derelji onuqtun jaluus gēd oroḡ šarxoliyin buruu beyēr kiyisen odbo: uwaši xon tayijiyin xayirladaḡ²³⁷ jaluus noyon-niyinōn²³⁸ yasun dēre dörbön

²²³ Г.Г-ын эхэд "ulu köp" (урт хөл) гэж буй. Г.И.Рамстедт "хөл" (2-337) гэж малын тоо болон мал гэсэн утгаар Халимаг хэлэнд хэрэглэдгийг тэмдэглэж, жишээ үг егүүлбэр авсан байна. Туужийн энэ хэсэгт "урт хөл" гэж "тэмээ"-г нэрлэсэн ажээ.

²²⁴ Г.Г-ын эхэд "gederegēn yaryal ügei urālān" гэж буй.

²²⁵ Г.Г-ын эхэд "dayilaba" гэж буй. Мөн залган өгүүлэх өгүүлбэрийн эхэнд "tegēd" гэж буй.

²²⁶ Г.Г-ын эхэд "muudaji" гэж буй.

²²⁷ Г.Г-ын эхэд "tuqgiyini" гэж буй.

²²⁸ Г.Г-ын эхэд "sērdengke" гэж буй.

²²⁹ Г.Г-ын эхэд "xobčasuyilan" гэж буй. Энэ эхэд "хувцсыг тань" гэсэн бол Хернхүтийн эхэд "хувцаснаас тань" гэсэн байна.

²³⁰ Г.Г-ын эхэд "dabastu" гэж буй.

²³¹ Г.Г-ын "А" эхэд "šounōstan", "В" эхэд "šouserēstan" гэж буй. "В" эхийн бичлэг болон Хернхүтийн эхийн бичлэг тварч байхаас гадна утгын тухайд ч "шүүснээс тань" гэх нь зөв буй.

Г.И.Рамстедт "Халимаг хэлний толь"-доо, "шүүс" гэж өөлд аман аялгуунд ван ноёдын үдийн зоогийг, дөрвөд аман аялгуунд давстай шөлийг хэлдэг гээд, манжаар "šusu" гэдэг болохыг бас заажээ. (2-373)

²³² Г.Г-ын эхэд "nere" гэжээ. Хернхүтийн эхийн "nerēn" (нэрийн) гэсэн бичлэг хам сэдвийн утгандаа нийцэж буй.

²³³ Г.Г-ын эхэд "čičiqsen-düni" гэж буй.

²³⁴ Г.Г-ын эхэд "la-čigi xarixu ügei biyija ta" гэсэн хэсэг Хернхүтийн эхэд орхигджээ. Хернхүтийн эхийн "čini ayixu ügei" гэсэн үгс Г.Г-ын эхэд үгүй байна.

²³⁵ Г.Г-ын эхэд "xaraji" бус "хәгји" гэсэн байхаас гадна "la" гэдэг үг үгүй байна.

²³⁶ Г.Г-ын "А" эхэд "ničidei", "В" эхэд "ničēdiyini" гэж буй. Хернхүтийн бичлэгийн хэлбэр "В" эхтэй тохирч байна.

²³⁷ Г.Г-ын эхэд "xayirildaḡ" гэж буй. Хернхүтийн эхийн бичлэг нь бичгийн хэлний зөв бичих зүйд нийцэж буй.

²³⁸ Г.Г-ын эхэд "noyoniyinān" гэж буй.

oyiridiyin čereq dunda²³⁹ morini-nōn morduxu talki dōrōgün²⁴⁰ utalād²⁴¹ mōn
 tōundū čabčildan bayiji ūkūqsen dōrbōn oyirid mongyolai²⁴² daruqsan ene:
 [8b.] oyiridiyin sakuusun dolōn nastai kōbōūn-dū xobilji²⁴³ mongyoldu čaling
 orkiqsani tere²⁴⁴ ʒal ʒaxai jil belci:-²⁴⁵

Тод эхийг кирилл үсэгт буулгасан хөрвүүлэг

[1a.] Монголын Уваши хун тайж, уулын хар барс болсон Урианханы Сайн Мажиг хоёулаан Хангайн Хар булагаас харь Дөрвөн Ойрдыг дайлъя (байлдъя) гэж найман түмэн цэрэг мордож ирэхдээн, Налаху Үхэрийн даваа давж, Нал хар бөөрөгт найман түмэн цэрэг хүрч ирж, Дөрвөн Ойрдын нутагт дөрвөн анги туршуул тавьж, олж ядаад, Монголын Уваши Хун тайж сайн, муу, дунд гурвуулан чуулга чуулаад, Урианханы Сайн Мажиг эхлэн олон сайдуудад, Уваши хун тайж зарлиг болвой. Зээ, залуус сонсогтун. Дөрвөн ойрдын занги (мэдээ, байдал) нь хотондоон ирсэн дайсанд, холч (сонор сэргэг) морин, хоточ нохой хэвтэй (шиг, адил) тарамдаж (гэнэт дайран довтолж) үл алддаг биш үү. Дөрвөн Ойрдод хэлүүлээд харих нь яалтай гэнээта (ямар гэж бодно та) залуус минь, санасан санаа энэ. Зөвшөөрөгтүн харъя. Буруушаагтун явъя гэжээ. Уваши хун тайжийн энэ зарлигийн хариуг уулаас (уулын) хар барс болсон Урианханы Сайн Мажиг ураалаан (урагш давшлан) суугаад, Уваши хун тайжид мэдүүлжээ. Ноёдын зарлиг зөв боловчиг (боловч) Монголын Уваши хунтайж, Урианханы Сайн Мажиг хоёулаан Хангайн Хар булагаас харь Дөрвөн Ойрдыг үзье гэж ирээд, цэрэг мордож ирэв гэхийг харь халуун ойр хол хэн биш (бусад)

[1б.] сонссон, Одоо малын барааг үзээд, айж зулж (зугатааж) харих нь үрийн үрд муу нэр сонсогдох бийза (бизээ), ноёд гэв. Монголын сайн, муу, дунд гурвуулан үүнийг зөвшөөгөөд, Уваши Хун тайж зарлиг болвой. Дөрвөн Ойрдын нутаг өмнөчиг (өмнө ч) бийза. Хойночиг (хойно ч) бийза. Альд гэж явна та гэв. Урианханы Сайн Мажиг ноёдын зарлиг зөв, Дөрвөн Ойрдын нутаг их боловчиг (боловч), нэг тивд хамт байдаг. Найман хоногоор болзье. Нарийнаар

²³⁹ Г.Г-ын эхэд "dunda" гэсэн үгийн хойно "emēliyinēn" гэж буй. Хөрнхүтийн эхэд энэ үгийн оронд "morini-nōn" (мориныхоо) гэж байна.

²⁴⁰ Г.Г-ын эхэд "dōrōgēn" гэж буй.

²⁴¹ Г.Г-ын эхэд "utalād" гэж буй. Огтлох, хайчлах, тайрах гэсэн утгатай үг бөгөөд Г.И.Рамстедт Түнгүүс хэлэнд "utela- scheiden (огтлох, хайчлах, зүсэх)" (2-453) гэж байдгийг тэмдэглэжээ.

²⁴² Г.Г-ын эхэд "mongyoli" гэж буй.

²⁴³ Г.Г-ын эхэд "xubilji" гэж буй.

²⁴⁴ Г.Г-ын эхэд "orkiqsen tereni" гэж буй.

²⁴⁵ Г.Г-ын эхэд "ʒal ʒaxai jil bilii geqsen" гэж буй.

хайлгая гэв. Нааруу цааруу (нааш, цааш) явах газрыг нь би заасу гэв. Найман түмэн хүнээс даяар мэддэг хоёр зуун залуу гаргая. Бум зургаан түмэн агтаас дөрвөн зуун морь гаргая. Миний заасан газраар явж хайтугай. Оловчиг (оловч), эс оловчиг (оловч) найман хоногт иртүгэй гэв. Цугаараан үүнийг зөвшөөгөөд, хоёр зуун туршуулыг уулаан (уулын) хар барс болсон Урианханы Сайн Мажиг дагуулж гараад, цэргийн захад, Хар уулын оргил дээр гарч, хоёр зуун туршуулдаан Дөрвөн Ойрдын нутгийн зүг зааж өхдөөн (өгөхдөө), энэ зүгт явагтун. Өмнө тань Ирчис

[2а.] гэдэг гол гарах. Ирчисийг уруудагтун. Дээд бие нь хар модон, дорд бие нь шар хулсан, тэр хоёулын завсарт Маани гэдэг гаталган (олсм) бий. Түүгээр гатлагтун. Тэр талны (талын) өөд уруу хайгтун. Түүнд юман (юм) эс олдмогц түүнээсээн өөдлөс гээд эгцдээн гарагтун. Мангадар нь (маргааш нь) асгандаан (орой үдэшдээ) ус уухат (уугтун). Эмээлийн адаг Шар хулсан гэдэг намаг булагтай хар уул болдог. Түүгээр явж хайгтун. Түүнд юман эс олдмогц тэр ууланд шадархан (ойрхон) ирж тасардаг Бажи, Гинчилэй хоёр голын эхэн ирдэг түүгээр хайгтун. Энэ гурвуулаад (гурвууланд) юман эс олдохуна (олдохул, олдвол) харьж ирэгтүн. Чаднаста (чадах аваас) барьж ирэгтүн. Яднаста (ядах аваас, ядвал) үзэж ирэгтүн. Олдовчиг (олдовч), эс олдовчиг (олдовч) найман хоногт чангад явж, нааруу (нааш) ирж, зангиа (хэл мэдээгээ) өгөгтүн. Зээ, залуус та чиг (та нар ч) үйлээн бүтээж, мэндэсэн (мэнд эсэн) ирэгтүн. Би чиг (би ч) цэрэгтээн харису гээд харив. Тэгээд Сайн Мажигийн захиснаар Монголын туршуул Ирчисийн Маани гаталгаар гатлаад, тэр талны (талын) өөд уруу хайж юман эс

[2б.] олдов. Эмээлийн адаг Шар хулсаар хайвчиг (хайвч) нутаг эс олдов. Бажи Гинжилийн эхээр хайж явам гэхүүнэ хив бүстэй, хилин оймстой, долоон настай, гунан халтар морьтой хөвүүн харгалдав (дайралдав). Хөвүүг (хөвүүнийг) өрүүн (өглөө) хөөгөөд асган (үдэш) гүйцэж барив. Хоёр зуун туршуул дундаан авч суугаад, зангийг нь сурав (хэл мэдээг нь асуув). Хэнээб (хэнийх буй) чи, хөвүүн юу хийж явлаа чи, хэл! хөвүүн гэвээ. Байбагусны би, есөн цагаан тэмээн хайж явлаа би гэв. Дөрвөн Ойрд цэрэгтэй буй, цэрэг үгүй буй, нутаг нь альд байнай гэв. Хөвүүн хэлэв. Таныг сурж (асууж) ир гэсэн биш, барьж ир гэсэн биш үү. Ахад үг хэлдэг, дэвэлийн (дээлийн) захаар нь өмсдөг. Амьд хүргэгтүн. Амаараан хүрч мэдүүлсү гэв. Хөвүүний үг нь энэ. Засаж дуу гаргаж ядаад, зандаж үг сурж ядаад, айлгаж чиг (айлгаж ч) ядаад, аргадаж чиг (аргадаж ч) ядаад зөвчилдөвэй. Маныг (биднийг) сурж ир гэсэн биш, барьж ир гэсэн билээ. Үүнийг амьд хүргээ гээд аваад харив. Дөрвөн Ойрдын занги (хэл мэдээ) мэдүүл гэж хоёр хүн ураалаан (түрүүнд нь) илгээв. Дөрвөн Ойрдын

[3а.] захаас долоон настай хөвүүн барив бид. Занги (хэл мэдээ) нь энэ гэв. Монголын Уваши эхлэн олон сайн, муу, дунд гурвуулайд

(гурвууланд) үүнийг хэлж байтал, долоон настай хөвүүг (хөвүүнийг) авч ирэв. Хөвүүг хатуу үгтэй хөвүүн гэхийг сонсоод, найман хөлтэй зандан ширээ дээр илд сугалаад тавив. Уваши хун тайж найман тэрэмтэй (ханатай) хар цоохор барсын арьсаар бүрсэн хош өргөөд (аяны өргөөд) долоон настай хөвүүг авч ирэв. Найман хөлтэй, зандан ширээ дор сөгөтгөж суулгаад, хоёр гарыг нь ард нь хүлээтэй, баруун өвдгийг нь уулын хар барс болсон Урианханы Сайн Мажиг дарж суун, зүүн өвдгийг нь Баахан Цэцэн дарж суун, Уваши хун тайж хөвүүний үгийг сурахдаан (асуухдаа), зээ, исэл (балчир) хөвүүн үгээн хэл гэв. Дөрвөн Ойрд цэрэгтэй бий? (буй?) Цэрэг үгүй бий? (буй?) Юу хийж байна гэв. Тэгмэгц, хөвүүн Уваши хун тайжид мэдүүлжээ. Ноёд айлгал үгүй сурагтун. Алдал үгүй мэдүүлье. Хохимнол үгүй (бачимдуулгүй) сурагтун. Хоцрол үгүй мэдүүлье. Дөрвөн Ойрд зараагийн үсэн, хөрөөгийн шүдэн болж,

[3б.] дөрвөлжин тэгэлцэг (тэгш өнцөгтийг тавьсан мэт бах бэх) байдаг. Мэдсэнээ мэдүүлье. Үл мэдсэнээ мэдүүлж болох үгүй байна. Уваши хун тайж хөвүүний тэр үгэнд боогдоод, Ойрдын наад захад хэн байна? Цэрэг, нутаг боловчиг (боловч) хэл гэв. Хөвүүн мэдүүлнэ. Амитийн (хамгийн) наад захад, тож мөнгөн дуулгатай, товруут улаан хуягтай, таж торгон улбатай (хүрэмтэй) тон (ирвэс зүүлт тайлбар 86 дугаарыг үз.) цоохор морьтой Мангадын хөвүүн Сайн Сэрдэнхэй хоёр мянган залуугаан дагуулсан, хоёр мянган жадаан хатгасан, хоёр мянган морион сойж орхисон гөрөөлөх гөрөөсөн бол уу, дайралдах дайсан бол уу гэж шүдээн хавирч, шүлсээн залгиж суудаг. Ноёд, түүнд дуран тань ямар байна? Исэл (дорой, эгэл жир) тэр чинь гайгүй. Түүний цаа (цаана) хэн байдаг бий? (буй?) хэл гэв. Ирчис голын эхэнд буусан Ирчин Харчин хоёр отгоо цуглуулж, хар эртэгчиний (хумагар нумын) элгэн хэвтэй (шиг) илэрч, Хойд Исалбайн Сайн Хиа дөрвөн мянган залуугаан дагуулсан, дөрвөн мянган жадаан хатгасан, дөрвөн мянган морион сойж орхисон,

[4а.] үхэлдэх дайсан бол уу? үгцэх (маргах, мэтгэх) залуу бол уу? гэж шүдээн хавирч, шүлсээн залгиж суудаг. Ноёд түүнд дуран тань ямар байна гэв. Исэл тэр чинь гайгүй. Түүний цаа (цаана) хэн байдаг бий? (буй?) хэл гэв. Өрүүгээр (өглөөгүүр) олон хойнд (хонинд) довтолсон оготор хөх чоно хэвтэй (шиг) өлөнгөдсөн бүргэдийн нүд гарсан Зүүн гар Хотгойт Хар Хула зургаан мянган хүн тэр хэвээр байдаг. Ноёд, түүнд дуран тань ямар байна? Исэл тэр чинь гайгүй, түүнээс чинь цаа (цаана) хэн байдаг бий? (буй?) хэл гэв. Нарийн голын эхэнд, нарийхан шарга морьтой, найман мянган цэрэгтэй ут (урт) голын бэлчирт Ойрдын Сайн Тэмнэ баатар тэр хэвээр байдаг. Ноёд, түүнд дуран тань ямар байна гэв. Исэл тэр чинь гайгүй, түүний цаа (цаана) хэн байдаг бий? (буй?) хэл! гэв. Алах булаахдаан дуртай арван барс дуутай Агайн (Агай хатны) таван барын ах хошууд Байбагус хаан түмэн зургаан мянган залуугаан дагуулсан, арван таван тэрэмтэй

(ханатай) алаг Байванхаан дундаа Дөрвөн Ойрдын төр шажин хоёрыг хүүнэж (хүүрнэж), дөрвөн зүгт надлай (надтай)

[4б.] адиллалцах нэгэн чинээн хүн үгүй буй заа гэж амаан ангайж, алгаан сарвайж суунаа гэдэг. Бие минь муу хүний хөвүүн буй. Нас минь долоон настай. Дөрвөн Ойрдыг эргэсэн үгүй би. Ойрдын хөвүүн дөрвөн зүгт бий. Миний занги (хэл мэдээ) энэ гэв. Тэгээд, Уваши хун тайж тэр хөвүүг авч гарч туг тай! (тахь!) гэв. Хоёр хүн авч гартал, ноёдод үг мэдүүлнээ би гэв. Дахиж суулгаад, зээ, исэл хөвүүн үгээн хэл гэв. Хөвүүн хэлнээ. Монголын Сайн Лайхар хаан Дөрвөн Ойрдын сайн ноёд хоёр Эмээлийн адаг Шар Хулсанд байр хийгээд (байлдаад), элтээд (эвлэж найрамдаад) харихдаан хүүнэлдэв (ярилцав) гэж эс билүү? Хэл барьсан хүнээ, хэлүүлээ байж алдаг болж гэмээ нь хэл тасарч хоцорьё гэж андгаар (тангараг) алдав гэж эс билүү. Хэлсэн сайн үгээн мартаж, хийсэн сайн андгаараан (тангарагаа) мартаж, намайг юунд үхүүлнээ та. Нас минь долоон настай, муу хүний хөвүүн билээ би. Амийг минь хайрлагтун ноёд гэв. Уваши хун тайж, түүнд хариу зарлиг эс болж, бас хөвүүг хоёр хүн авч гартал,

[5а.] Ойрдын занги (хэл мэдээ) мэдүүлнээ би гэв. Хэл! хөвүүн гэв. Алах, булаахад дуртай, арван барс дуутай, Агайн (Агай хатны) таван барын ах Хошууд Байбагус хаан хэлнээ билээ. Уваши хун тайжийн харчигинагийг нь (хош гэдсийг нь) дэрлүүлж, хар цусыг нь асгаруулж, хар тугийг нь хамгийн хаалгад (замд) хугачиж орхиод, хайрладаг Дара хатанлай нь (хатантай нь) нийлж, цусан улаан хацрыг нь үнэсч, цуудай (цав цагаан) цагаан биеийг нь тэвэрч, артай цагаан арвинд нь (харвинд нь) арван хар савраан хүргэж, будмал улаан халхад нь (хацарт нь) буянт сайхан сахлаан хүргэж, буян хишиг хоёрыг нь эзлэв гэж Бэмбэдээс (тайлбар 151 дүгээрийг үз) авсан гянт болд илдээрээ, хатааж хийсэн хар болд тулгаа гал гартал чавчив гэдэг. Тэр хэлснийг та санаж үл байна уу та. Тэгээд хөвүүг авч гараад туг тайв. Монголын туг ерөөх хүн эс гарчээ. Тугийн эзэн би болов. Би ерөөхүнө (ерөөхүл, ерөөвөл) ямар уу гэв. Хөвүүн сайтар ерөө! Би чиг (би ч) ерөөсү. Та чиг (та ч) сонсогтун. Хайрхан дайч тэнгэр идэж уугтун. Уваши хун тайжийн хар цусыг нь асгаруулав. Харчигина

[5б.] гийг нь дэрлүүлэв. Хар туг нь хамгийн хаалгад (замд) хугаран хоцров. Хайрладаг Дара хатныг хамгийн эзэн Байбагус ав. Ут (урт) хар туг нь Ойрдын хөлд хугаран хоцров. Оройн (Г.Г эхэд "орогийн") орог шаргал морин нь улаан торгон цулбуураан унжуулаад явсныг Ойрдын нэг хөвүүн жолоогоос нь жадаар өлгөөд зогсох болтугай. Бачи-д балбартлаан чичүүлэгтүн. Хөдөөд хүүрмэг болтлоон чичүүлэгтүн. Эмээлийн олом (Эмээл голын гатлага) Долоодайд элэг бөөрөө авагтун. Хадаан (Хадын) эхэнд хайвруулан чичүүлэгтүн. Булагтын голд бутанаан сандаан чичүүлэгтүн. Буян хишиг хоёрыг тань Ойрдын хөвүүн авах болтугай. Ууланд хүрээд онха (тонгорцог)

байгтун. Хөвүүний амь нь тэгээд гарав. Тэгээд Монголын цэрэг нийтээр тумагч (өлгөгдөгч) тэр хөвүүний үгэнд үнэн худал боловчиг (боловч) муу ерөөл болов гэж, энэ юу болов гэж их зовжээ. Тэгэвчиг (тэгэвч) Монголын сайн Уваши хун тайж дайнаас зулж (зугатааж) харив гэх нэр сонсохын оронд сайдах, муудах боловчиг (боловч)

[6a.] яван байж хэрээн мэдье гээд явав. Ирчис голыг гатлаад Эмээлийн адаг Шар хулсаар яваад, Бачи Гинжилийн эхээр түүнд найман түмэн цэрэг бууж байгаад, арван гуравтайгаас наараан(нааш) гучин долоотой хүртлээн дайны хөлд үл эндүүрдэг Баахан Болбусуныг начин халтар морьтой нь Дөрвөн Ойрдод хоёр хоногоор болзоод, туршуул тавив. Уваши хун тайж, хош (аяны өргөө) ачсан, хотон цагаан тэмээгээн үхүүлээд, залуусаан ир гээд, магтаж сууж өгөв. Зээ, усанд ордог сэрхийн эвэр болсон, уулганд ордог улааны минь чих болсон залуус минь сонсогтун. Хар мөртэй хөвүүний хараал тэр биш үү. Харь Дөрвөн Ойрдын занги (хэл мэдээ) тэр биш үү. Хар хөлсөөн бүү хайрлагтун. Залуус, ноёндоон мэдүүлжээ. Хэзээ бус асгарав, цусан нэгэн, хэвтэв ясан нэгэн. Ноёдын өмнө үйлээн нөөх үгүй бид гэж хүржигнэсээр гарч одов. Тэгээд, Баахан Болбусун ирээд, Дөрвөн Ойрдын зангийг нь (хэл мэдээг нь)

[6б.] Уваши хун тайжид мэдүүлжээ. Дөрвөн Ойрд зараагийн үсэн болж, хөрөөгийн шүдэн болж дөрвөлж тэгэлцэг байна. Маныг (биднийг) аашин (айсуй) гээд саглаж (сэрэмжилж) байхыг нь чиг (ч) мэдэх биш би. Ер сагтай (сэрэмжтэй) байдгийг чиг (ч) мэдэх биш би. Ойрдын занги энэ гэв. Уваши хун тайж зарлиг болов. Дөрвөн түмээр уулгач хийгээд, дөрвөн түмээр эх хийгээд Ойрд уруу явахуна (явахул, явбал) яах бийза (буйза) гэнээж гэв. Баахан Болбусун мэдүүлэв. Дөрвөн Ойрдлай (Ойрдтой) байрлалдаад (байлдаад) өрүүн (өглөө) зулхуна (зулж дутаавал) хэл гарах бид. Асган (үдэш, орой) зулхуна хэл тасрах бид гэсэнд, Уваши хун тайж цухалдаад, үнэн худал боловчиг (боловч) хайран залуусын минь зүрх хатааж, хатуугаар хэлэв чи гэж өмнөх хөвүүний ёсоор зас (ялла!) гэв. Баахан Болбусун начин халтар мориороо арайхан гэж зулж (дутааж) гарав. Тэгээд Уваши хун тайж Урианханы Мажиг хоёр хойт нэрийн төлөө явахыг зөвшөөгөөд, уулган өрүүн (өглөө)

[7.a] тавья гэж байгаад, Уваши хун тайж уулган ураалаан (түрүүнд нь) тавьжээ. Урианханы Сайн Мажиг түүнд нь өөтөж (өөнтөглөж, гомдож), Хун тайжид мэдүүлжээ. Гэртээсээн гарч, явснаас нааран (нааш) олон буруу хийж явав чи. Одоо энэ бурууг чинь даах биш би. Хэл барьсан хөвүүнээ хэлүүлээ байж, үхүүлсэн нэг муу ёр чинь энэ. Найман хөлтэй зандан ширээнийхээ хөлийг нь хугачиж орхив чи. Хоёр муу ёр чинь энэ. Хотон цагаан тэмээгээрээн түлшээн (түлшлэх тайлгад) идүүлсэн гурван муу ёр чинь энэ. Одоо надаас дайны мал харамнаад уулга ураалаан (түрүүнд нь) тавьсан дөрвөн муу ёр чинь энэ. Хөтөч явсан нөхдөөсөөн дайны мал харамнасан учир чинь хар

нохойн цус харамнасан ялгал үгүй гэдэг бий (буй). Харина, би гээд түм таван мянган уулгачаан аваад харив. Хун тайж Дөрвөн Ойрдыг зорин явав. Урианханы Мажиг хүний дөрвөөд морьтой, хоёр мянган хүн тавьж, Баахан Болбусунд захиж, бөөрөөр хүрч довтлоод, хэлтгийгээр

[76.] харьж ир. Хэл барьж Дөрвөн Ойрдод занги (хэл чимээ) оруул. Нутаг минь Хангайн Хар Булагт, харь Дөрвөн Ойрд таныг үзье гэж ирлээ бид. Одоо дөрвөн түмэн хүн бий (буй), харив би. Наатан (наана тань) Уваши хун тайж цувсан сүрэг одов. Түүнийг яахаан өөрөөн мэдэгтүн гэж хэл оруул гээд илгээв. Мажигийн захисаар ураалаан (түрүүлэн) хүрээд, ут (урт) хөл олж аваад, ардаан хэл оруулжээ. Уваши хун тайжийн уулгач үхэр хой (хонь) олзлоод зогсжээ. Тэгээд Дөрвөн Ойрдын цэрэг нь цуглаж ирээд, Уваши хун тайжийг гэдрэгээн гаргал үгүй ураалаан (урагш) явуулал үгүй мөн түүнд нь буулгаад, гурван хоног дайлав (байлдав). Монголын цэрэг нийтээр муудаж ирэхлээр нь Уваши хун тайжийн хар тугийг нь чирээд, хайрладаг залуус аваад гарч явтал, Ойрдын Сайн Сэрдэнхэй олон цэргээс онц ороод, Уваши хун тайжид

[8a.] жад өргөхдөөн мэдүүлсэн үг нь, зээ, ноёод! Заарт хувцаснаас тань өмсч билээ би. Давст шүүснээс тань ихэд хүртлээ би. Тэгэв чиг (тэгэвч) харь Дөрвөн Ойрдын нэрийн төлөө баруун бөөрд тань жад өргөв би. Ноёод! Толгой минь тэр гээд чичсэн. Тэгээд Уваши хун тайж тэр шархдаан өөд болохын урьд орог шаргалыг тавигтун. Нутагт занги (хэл чимээ) оруултугай. Та чиг (та нар ч) харих үгүй бийза (буй за) та. Айх үгүй харж үхэв гэх хайран нэрээн санаж, нэжээдийг нь дэрлэж орогтун залуус гээд, орог шаргалын буруу биеэр хийсэн одов. Уваши тайжийн хайрладаг залуус, ноёныхоо ясан дээр Дөрвөн Ойрдын цэрэг дунд мориныхоо мордох талын дөрөөгөөн утлаад (огтлоод) мөн түүнд чавчилдан байж үхсэн. Дөрвөн Ойрд Монголыг дарсан энэ.

[8b.] Ойрдын сахиусан долоон настай хөвүүнд хувилж, монголд цалин (цалиг) орхисон нь тэр гал гахай жил билээ.

Зүүлт тайлбарт эш татсан ном зүй

1. Гомбоев Г, *Алтан тобчи, монгольская летопись в подлинном тексте и переводе с приложением калмыцкого текста истории Убаши-хунтайджия и его войны с ойратами*, -ТВОРАО, т. VI, 1985.
2. Ramstedt G.J, *Kalmükisches Wörterbuch*, Helsinki, 1976.
3. Цолоо Ж, *БНМАУ дахь Монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг*, II дэвтэр, Ойрд аялгуу, Улаанбаатар, 1988
4. *Калмыцко-русский словарь*, Под редакцией Б.Д.Муниева, Москва, 1977.
5. ce. damdinsürüng, *mongyol uran jokiyal-un degeji jayun bilig ogusibai*, Улаанбаатар, 1959.
6. *Убаши Хун тайжийн тууж*, Ц.Дамдинсүрэн хэвлэлд бэлтгэв, Улаанбаатар, 1956.
7. Батмөнх Б, *Ойрад монголын түүхэд холбогдох тод үсгийн сурвалж бичгүүд*, Улаанбаатар, 2002.
8. Дамдинсүрэн Ц, А.Лувсандэндэв, *Орос-монгол толь*, Улаанбаатар, 1982
9. Цэвэл Я, *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар, 1966.
10. Rachewiltz Igor de, *Index to the secret history of the mongols*, Bloomington, 1972.
11. Цэрэнсодном Д, *"Монголын нууц товчоо"*, Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар, Улаанбаатар, 2000.
12. Sečenşoytu, *"Mongyol üges-ün ijayur-un toli"*, Köke qota, 1988.
13. *Древнетюркский словарь*, Ленинград, 1969.
14. Dobu, *uigurjin mongyol üsüg-ün durasqaltu bicig-üd*, begejing, 1983
15. Бобровников А, *Грамматика монгольско-калмыцкого языка*, Казань, 1849
16. eldentei, oyundalai, asaraltu jokiyaba ardajab, secenjuw-a mongyolcilaba, *"mongyol-un niyuca tobciyan"-u jarim üges-ün tayilburi*, begejing, 1991
17. *Qorin naimatu tayilburi toli*, Namjilm-a emkidkebe, ЭМАХХ, 1994, Köke qota,
18. *qayan-u bicigsen tabun juil-ün üsüg qabsuruysan manju üge-yin toli bicig*, II boti, begejing, 1957
19. soyijungjab, gereltü nar nayirayulba, *oyirad ayalyun-u uges*, kokeqota, 1998
20. Martti Räsänen, *Versuch eines etymologischen wörterbuchs der Türksprachen*, Helsinki, 1969.
21. *Qorin nigetü tayilburi toli*, Kökeqota, 1979.
22. А.Позднеев, *"Калмыцкая хрестоматия" для чтения в старших классах калмыцких народных школ*, (издание второе), Санктпетербург, 1907
23. norjin, *mongyol kelen-ü toli*, öbür mongyol, 1999
24. altanša. n, *mongyolcud-un öcүgedür-ün mör*, II debter, ulaanqada qota, 1993

25. Чоймаа Ш, *qad-un ündüsün qeriyangyui altan tobci (эх бичгийн судалгаа)*, Тэргүүн дэвтэр, Monumenta Mongolica, tomus II, Centre for Mongol studies ngational university of Mongolia, Улаанбаатар, 2002
26. Пэрлээ Х, *Увш хун тайжийн туужид гарах түүхэн он цагийг судалсан тухай*, "Studia Mongolica", Tom VI (II), Fasc 1-18, 88-94
27. Поппе Н.Н, *Монгольский словарь Мукаддимат-ал-Адаб*, Москва-Ленинград, 1938
28. Цолоо Ж, *Арван гурван хүлгийн дуун (Ойрд аман зохиолын цоморлиг)*, Улаанбаатар, 1987
29. Шамский Н.М, *Краткий этимологический словарь русского языка*, Москва, 1971
30. *Словарь русского языка*, главный редактор А.П Евгеньева, Том II (К-О), Москва, 1999
31. John R.Krueger, *Oirat-Mongolian Draft Dictionary*, Bloomington, Indiana, 1977

Орлогын дараа ..

Эхний үеийн

Хүн амын өсөлт

Хүн амын

Урьдчилсан үнэмлэхүй гүйцэтгэл
Хүн амын өсөлт

Кафедра монгольской филологии Московского
Государственного Университета имени Ломоносова,
Чоо Сагсала.

Ринчен.

Обратская историческая поэма о монгольском
ском Убаши-сум-тайгни.

Убаши-сум-тайгни
Ринчен

महाराज

दिल्ली में

आज (शुक्रवार) को

आज (शुक्रवार) को